ҮНДЭСТНИЙ

ТОЙМ

ДЭД ТӨВ ХЭМЭЭХ НЭН ЗӨВ ШИЙДЭЛ

Арнауд Хэкманн:

ГЭР ХОРООЛОЛД ДЭД БҮТЦИЙН ШУГАМ СҮЛЖЭЭГ ЦОГЦООР НЬ БАРЬЖ БАЙГУУЛАХ ХЭРЭГТЭЙ

2021.12.13
№37 (498)

10000₮

#Гарчиг

Дугаарыг удирдсан
Х.Батсайхан

ТОЙМ
2021.12.13
№37 (498)

#Дуран
2

#Эшлэл
4

#ОнцлохНийтлэл
6 Дэд төв хэмээх нэн зөв шийдэл

#ЗүгЧиг
12 Арнауд Хэкманн: Гэр хорооло дэд бүтцийн шугам сүлжээг цогцоор нь барьж байгуулах хэрэгтэй
16 Дэд төв: Өнгөрснөөс өнөөдрийг хүртэл...

#Бид
24 Д.Авирмэд: Дэд төвийн хөгжилд иргэдийн оролцоо хамгаас чухал
27 Улаанбаатарын хүмүүс: Хот доторх "ХОТ"-ын иргэд
31 Ногоон дээвэр
32 Б.Сүхбаатар: Хэт төвлөрлийг сааруулж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно
34 Яндангүй бол утаагүй

#Матар
36 Шүүмжлэлдээ шүүмжлүүлсэн минь

Дэд төв байгуулах төсөл зарлагдсан цагаасаа л гэр хорооллын оршин суугчдын сэтгэлд итгэлийн гал асааж, багагүй хүлээлт үүсгэсэн билээ. Тэгвэл хүлээлт дуусч, найдлага биелэхэд багахан хугацаа үлдээд байна. Дэд төвүүдийн бүтээн байгуулалт зөвхөн дэд бүтэц барьсангүй, иргэдийн харилцаа хандлагыг ч мөн давхар "барьж байгуулж" явна. Өмнө нь "Бүтээн байгуулалтын ажил" гэхээр иргэд өөрсдөд нь огт хамаагүй мэт ханддаг байсан бол одоо харин иргэдийн, тэр тусмаа Дэд төвийн төслийн талбайд багтсан айл өрхүүдийн чих тавьдаг, сонирхдог ганц зүйл нь болсон гэхэд хилсдэхгүй. Гэр хорооллыг хөгжүүлэх ажил нь нүдэнд харагдаж, гарт баригдахуйц урагштай үргэлжилж байгаа болохоор их л сэтгэл өөдрөг, итгэлтэй байна. Иргэдийн энэ итгэлийг бататгаж буй хамгийн том хүчин зүйл нь нүдэнд үзэгдэж, гарт баригдаж буй Дэд төвүүдийн бүтээн байгуулалт.

Дэд төвүүд баригдсанаар нийслэл нэг төвт хотоос олон төвт хот болж хөгжинө. Дэд төвд одоогийн хотын төвд байгаа, заавал ирж авахаас өөр аргагүй байдаг үйлчилгээ нөхцөл бүгд бүрдсэн байна. Хот гэдэг үгийг хэлэхэд хүмүүсийн санаанд хамгийн түрүүнд орон сууцны тохилог хороолол, цэвэрхэн саруул гудамжууд буудаг. Тэгэхээр энэ бүхнийг шийдэх инженерийн хувьсгал бол гэр хороолол дахь Дэд төвүүд. Нэг ёсондоо Дэд төв бол хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах, иргэдийнхээ хуулиар баталгаажсан эрхийг эдлүүлэх олон талын ашигтай түлхүүр мөн. ■

Нийтлэлийн бодлогын зөвлөлийн дарга: Бат-Эрдэнийн Батбаяр **Ерөнхий эрхлэгч:** Чулуунбатын Гангэрэл **Тоймч:** Ядамсүрэнгийн Баяраа, С.Лхагвасүрэн, Д.Дамдинжав **Маркетингийн алба:** Б.Нарантуяа 88006486 **Гадаад мэдээллийн тоймч:** Х.Батсайхан, Г.Ганбаяр **Улс төрийн тоймч:** С.Шийлэгтөмөр, Б.Цэнд-Аюуш **Эдийн засгийн тоймч:** С.Сосоржав **Спортын тоймч:** Д.Жавхлан **Урлагийн тоймч:** Б.Алтанхуяг **Сэтгүүлч:** Т.Батцэцэг, Б.Болор-Эрдэнэ, О.Даваасүрэн, **Дизайнер:** Д.Жавхлан **Эрхлэн гаргагч:** ТОЙМ Inc ХХК **Улсын бүртгэлийн дугаар:** 9011018008 ISSN 1993-0763 **Хаяг:** СБД, 1-р хороо, Жамьян гүний гудамж-3, Чандмань төвийн байр 501 **Утас:** 70149911 **E-mail:** toimch@gmail.com http://twitter.com/toimsetguul.mn

ЖДҮ-чдийн өргөөг нээв

Нийслэлд анх удаа Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөгжлийн төвийг Сэлбэ дэд төвийн Бизнес инкубатор сургалтын төвийн байранд байгууллаа. Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банк, НЗДТГ хамтран энэхүү төвийг ашиглалтад оруулж, бизнес эрхлэгч нарт зориулан олон улсын стандартын дагуу тохижуулсан байна. Улаанбаатар хотод 700 мянган жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, өрхийн бизнес эрхлэгч бий. Бичил бизнес эрхлэгчид уг төвөөр дамжуулан санхүү, маркетинг, хууль эрх зүй, мэдээлэл технологи, инновацыг хөгжүүлэх, хөдөлмөр зуучлалын зэрэг зөвлөх үйлчилгээг авахаас гадна төрөл бүрийн сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой.

Б.Бямба-Очир/МРА/2021.09.09



Урлагийн хот

Уран барималч А.Очирболдын “Ухамсар” бүтээл Энхтайваны өргөн чөлөөний нийтийн эзэмшлийн талбайд заларлаа. “Урлагийн хот Улаанбаатар” аяны хүрээнд дүрслэх урлагийн бүтээл туурвидаг уран бүтээлчдийг олон нийтэд таниулах, тэднийг дэмжин ажиллах зорилгоор цаашид уг талбайд орчин үеийн контемпорари бүтээлүүдийг цувралаар байрлуулах юм.

Д.Занданбат/МРА/2021.09.22

Сэлбийн сэргэлт

Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрийн нийт 156 га газарт Сэлбэ дэд төв буюу нийгмийн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг цогцлоож байна. Дэд төвийн тохижилтын ажил бүрэн дуусаж, үерийн хамгаалалтын далан сувгийн дотор ханын цутгалт болон далангийн дагуух нийт 3.01 га газарт шаварлаг хөрсийг солилоо. Мөн ногоон байгууламж, сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбай, чийрэгжүүлэх төхөөрөмж, иргэдийн амарч суух сандал, сүүдрэвч, явган хүний зам зэргийг цогцоор нь шийдэн тохижуулжээ.

НЗДТГ-ын Хэвлэл, мэдээлэлтэй харилцах хэлтэс/2021.08.02

Эртэч Улаанбаатарын "Өглөөний гудамж"

Усалгаа арчилгаатай цэцэрлэгт хүрээлэн, үнэгүй интернэт, дугуйн зогсоол, дасгалын тайз зэргийг бүрдүүлж, иргэдийн чөлөөт цагаа зөв өнгөрөөх орчин бүхий ирээдүйн Улаанбаатарын дүр төрх бүрдэж эхэллээ. Их хотын өнгө үзэмжийг сайжруулахын зэрэгцээ нийслэлийн иргэдээ амьдралын зөв хэмнэлд уриалах жишиг гудамжийг дүүрэг бүрд байгуулахаар зорьж буй. "Өглөөний Улаанбаатар" төслийн хүрээнд 2021 онд хоёр байршилд автомашингүй орчин бүрдүүлсний нэг нь Гутлын 22 буюу Жуулчны гудамж.

2021.08.02

Монгол Улсын Ерөнхий сайд
Л.Оюун-Эрдэнэ

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТ СТАНДАРТТАЙ БАЙХ ЁСТОЙ.

Хэдэн байшингийн дунд нэг зогсоол, спорт төв байх юм, нийслэлийн хэмжээнд хэдэн машин зорчих боломжтой юм, ногоон байгууламж нь ямар байх юм гэхчлэн стандартыг тогтооё.

Бодит байдлыг ард нийтэд мэдээлье, сурталчилъя. Бодит байдлаас илүү үнэн гэж байхгүй. Энэ бүх асуудлыг шийдвэрлэхэд Засгийн газар болоод УИХ-ын зүгээс ямар дэмжлэг, туслалцаа, тогтоол, шийдвэр хэрэгтэй байгааг танилцуул.

Эрх зүйн түвшний шаардлагатай шийдвэрийг Засгийн газар бүрдүүлж өгье. Шийдвэр гаргахад “Ногоон гэрэл” асааж өгье.

eagle.mn

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

Д.Сумъяабазар

Дэд төвийн хамрах талбайд инженерийн шийдлүүдийг хэсэгчилсэн байдлаар шийдэж, үүнийг тойрсон нийгмийн барилга, байгууламж барихаар төлөвлөсөн. Дулаан, цахилгаан, цэвэр, бохир усаа өөрөө шийднэ. Эдгээр газарт төрийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж эхэлбэл иргэдийн газар эргэлтэд орж, үнэд орно. Зургаан дэд төв 2024 он гэхэд ашиглалтад орсноор 60 мянган айлын орон сууц барих инженерийн дэд бүтэц бэлэн болно.

ulaanbaatar.mn

Европын Хөрөнгө Оруулалтын Банкны төлөөлөгч

М.Ауво Кайкконен

Иргэдийн амьдралын стандартыг сайжруулж, хотын орчныг хөгжүүлж, олон гэр бүлийг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулахын тулд гэр хорооллын бүсэд дэд бүтцээс эхлээд зам, ус, цахилгаан, харилцаа холбоо болон иргэдийн орлогод нийцсэн орон сууц гэх мэт байгууламжуудыг шийдэх хэрэгтэй. Иймээс ЕХОБ-наас одоо Улаанбаатар хотын гэр хороололд хэрэгжиж байгаа төслийг дэмжиж, энэхүү төслийг боломжтой хүртээмжтэй байлгах дээр анхаарч хэрэгцээтэй хүн бүрт хүргэх тал дээр ажиллана. Бид энэхүү төсөлд урт хугацаандаа дэмжлэг үзүүлэн ажиллах болно. Төсөлд хамтран ажиллаж, сэтгэл зүрхээ зориулж байгаа бүх оролцогч талуудад талархал илэрхийлхийн хамт төслийг АХБ-тай хамтран санхүүжүүлж байгаадаа баяртай байна.

Сангийн сайд

Б.Жавхлан

Хотын захад амьдарч байгаа хэдий ч хотын төв орох шаардлагагүй төрийн үйлчилгээ авдаг болох, тийм орчныг бий болгоход дэд төвүүдийн зорилго оршиж байна. Хотын төвөөс томоохон төрийн байгууллагыг нүүлгэх бодлогыг Засгийн газар барьж байгаа. Эхнээсээ яамд, томоохон төрийн байгууллагууд нүүхээр саналаа ирүүлсэн.

gogo.mn

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Ж.Батбаясгалан

Монгол Улсыг хөгжүүлэх урт хугацааны бодлого, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн төлөвт хэт төвлөрлийг сааруулах, гэр хорооллыг хөгжүүлж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийн амьдрах нөхцөл, өрхийн эдийн засгийг сайжруулахаар хот зорьж байна. Тэр дундаа хот байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх ажлын хүрээнд хотын хэт төвлөрлийг задалж, нэг төвөөс олон төвт суурьшлын зохистой тогтолцоонд суурилсан хотыг байгуулах хариуцлагатай үүргийг гардан гүйцэтгэж буй Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн баг хамт олон “Сэлбэ”, “Баянхошуу” дэд төвүүдийг ашиглалтад оруулаа. Гэр хороолол дахь инженерийн хувьсгалын эхлэл болсон энэ бүтээн байгуулалтын үр дүнд 21 мянган өрх, 100 гаруй аж ахуйн нэгж нэгдсэн дулаан, ариутгах татуургын шугаманд холбогдон, Дамбадаржаа, Баянхошуунд амьдардаг 50 мянга орчим өрх ундны цэвэр усны нөөцөөр хангагдах боломжтой боллоо.

citycouncul.mn

Улаанбаатар хотын урагшлах зам таг гацсан байдалтай удлаа. Шинээр төлөвлөх, зохион байгуулах гэхээр дэд бүтэц, эко системийн хувьд байгаа нөөц нь шавхагдсан тул аргагүй мухардчихаад буй. Тиймдээ ч цааш хөгжих замыг хотын түгжрэлтэй адилтган, жишиж дүгнэх нь нэн олон.

Улаанбаатар хотын анхны ерөнхий төлөвлөгөөг ЗХУ-ын мэргэжилтнүүд батлахдаа, ердөө хагас сая хүнтэй хот байхаар бодож тооцсон. Хэдийгээр анхны төлөвлөгөөг өнгөрсөн хугацаанд 5 удаа шинэчлэн засч, хэрэгжүүлсэн хэдий ч анхны суурьшсаа огтхон ч гажилгүй өдий хүрчээ. Юу гэвэл, Улаанбаатар хотыг анхнаас нь нэг төвтэй байхаар тооцож, тэрхүү цөмөө тойруулж хотжилт үүсгэхээр төлөвлөсөн. Хамгийн ихдээ хагас сая хүнтэй хотод л зориулж хийсэн төлөвлөлт учраас буруутгах ч аргагүй. Харин социализмын үеэс хойш нийслэлийн нийгэм, эдийн засгийн эрчимтэй тэлэлт, хүн амын бөөгнөрөл, машин техникийн хэрэглээ нэмэгдсээр байсан ч түүнийг дагасан дэд бүтцийн шинэчлэл огт хийгдсэнгүй. 1960-аад онд Улаанбаатар хотноо 120, 220, 40, 50 мянгат гэх хороолууд сүндэрлэн боссон. Үүнээс хойш 1980-аад онд нэг, гурав, дөрөвдүгээр хороолыг барьж босгосон. Ингээд үүнээс хойш бүтэн 40 жил өнгөрөхөд дээрх шиг томоохон бүтээн байгуулалт өрнөөгүйн гол шалтгаан нь дэд бүтэц юм. Зөвхөн хотын төв хэсгээ тойруулж дэд бүтцээ шийдсэнээс үүдэж, хотын төв хэсгийн ачаалал илт өсөв. Гэтэл тэрхүү төв хэсэгт хотын бүх хүн ам багтах ямар ч бололцоогүй билээ.

Ингээд Улаанбаатар хотын тэлэлт хэвтээ, босоо болон үсчсэн бүх хэлбэрээр эрчимтэй явагдаж, баруун зүүн тийшээ 30-40 км, урагшаа хойшоогоо 20-30 км үргэлжилсэн. Хэт олон хүн хотод шилжин суурьших болсноос үүдэж, дэд бүтэц хөгжөөгүй газруудад дур зоргоороо хашаа хатган, гэр барьж эхэлсэн. Уг үндсийг нь хөөвөл, яг энд ээс л Улаанбаатар хотын хамаг зовлон эхэлсэн байдаг. Дэд бүтэц хөгжөөгүй газарт гэр барьсан айлууд нүүрс түлэх болсноор агаарын бохирдол үүсч, бохир, цэвэр усны шугаманд холбогдоогүйгээс хөрсний бохирдол хүрээгээ тэлж, бүх үйлчилгээгээ хотын төвөөс залгуулдаг амь амьжиргаа нь нийтийн тээвэр, авто замын

Нийтлэлч
Д.Дамдинжав

ДЭД ТӨВ ХЭМЭЭХ НЭН ЗӨВ ШИЙДЭЛ

түгжрэлийг үүсгэжээ. Нийслэл үндсэндээ нэг л төвтэй. Сүхбаатарын талбайгаа тойроод төрийн бүх яам, агентлаг, худалдаа соёлын үйлчилгээ төвлөрснөөс болж түгжрэл үүсдэг. Аж төрөн суугаа газар орчиндоо буюу гэрийнхээ ойролцоо бүх хэрэгцээгээ хангаж байвал хотын төвийг өдөр бүр зүглэж, түгжрэх шаардлагагүй болно. Энд л Улаанбаатар хотын бэрхшээл бүхний шийдэл нуугдаж байж мэднэ.

Нийслэлд тулгамдаж буй гурван бүлэг асуудал бий. Үүний эхэнд, хотын дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хоёрт, хот руу шилжих хөдөлгөөн ихэссэний улмаас гэр хорооллын тэлэлт ордог. Тэгвэл гурав дахь асуудал нь, ердөө л дээрх хоёр нөхцөлөөс үүдсэн бэрхшээл хүндрэлүүд юм. Тухайлбал, агаарын бохирдол, хөрсний бохирдол, замын түгжрэл, орон сууцны хүрэлцээ гээд хөвөрнө. Тиймээс эхний хоёр шалтгааныг арилгавал дараагийн урхаг, үр дагаврууд дагаад алга болно гэсэн үг.

Цаашдаа Улаанбаатар нэг төвт хотын загвараар хөгжих боломжгүй болсон. Их, Бага тойруу гэх багахан гортиг руу тэмүүлэх хөдөлгөөн нь хотын түгжрэлийг бий болгож, хотын захдаа хотын хөдөө гэх хөгжлийн ялгаа заагийг нэгэнт үүсгэжээ. Тийм учраас хотын Дэд төв гэх нэр томъёо сүүлийн жилүүдэд эрчимжиж, төрийн бодлого үүнд төвлөрөх болов.

Улаанбаатарыг нэг төвт хотоос олон төвт хотын загварт шилжүүлэх санаачлага 2009 оноос эхлэн хүчтэй яригдсан. Тус гэр хорооло́лд Дэд төвүүдийг барьж байгуулах суурь судалгаануудыг эхлүүлж, 2012 онд “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн ТЭЗҮ-ийг баталлаа. Улмаар 2013 онд УИХ-аар санхүүжилтийн хэлэлцээрийг баталж, 2014 онд төслийн нэгжийг байгуулсан. Үнэндээ тухайн үед Дэд төвийн учир холбогдлыг ойлгож ухаарсан хүн иргэдийн дунд ховор байлаа. Тухайн үед *“10 жилийн дараа Нийслэл хот зургаан Дэд төвтэй болно”* гэдэг төлөвлөгөө ч хол хөндий, мөрөөдөл төдий сонсогдож байсныг хэлэх хэрэгтэй.

Дүүрэг бүр өөрийн гэсэн Дэд төвтэй болж, тэдгээр нь өнөөгийн Сүхбаатарын талбайг тойрсон хотын төв шиг болж хөгжинө гэдгийг сонсох үнэндээ хөгжилтэй байв. Дүүрэг бүхэнд иргэдийн эрэлт хэрэгцээг хангасан бүх төрлийн үйлчилгээ, дэд бүтэц, худалдаа, ажлын байр, мэргэжлийн албад, банк санхүү, нийгмийн үйлчилгээ, соёлын газрууд нэг дор төвлөрвөл иргэд заавал хотын төв орох шаардлагагүй. Хөгжингүй хотууд ийм л загвараар хотын төвлөрлийг сааруулдаг.

10 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар **(344.2 сая ам.долларaар)** хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын санхүүжилтыг Азийн Хөгжлийн Банк, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны хөнгөлөлттэй зээл болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж байгаа юм.

Үе шат 1

БАЯНХОШУУ ДЭД ТӨВ, СЭЛБЭ ДЭД ТӨВ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
33.15

Европын Хөрөнгө Оруулалтын Банк
22.01

Азийн Хөгжлийн Банк
53.7

Нийт: **108.86 сая ам.доллар**
Зарцуулалт: **98.74 сая ам.доллар**

Үе шат 2

ДАМБАДАРЖАА ДЭД ТӨВ, ДЭНЖИЙН МЯНГА ДЭД ТӨВ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
35.15

Европын Хөрөнгө Оруулалтын Банк
19.64

Азийн Хөгжлийн Банк
66.35

Нийт: **121.14 сая ам.доллар**
Зарцуулалт: **28.16 сая ам.доллар**

Үе шат 3

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ, ШАРХАД ДЭД ТӨВ

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
51.90

Европын Хөрөнгө Оруулалтын Банк
18.65

Азийн Хөгжлийн Банк
43.65

Нийт: **114.2 сая ам.доллар**
Зарцуулалт: **-**

Харин Монголд дүүрэг бүрт Дэд төв байгуулах хөрөнгө санхүүгийн боломжгүй тул эхний ээлжинд Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад гэсэн зургаан цэгт байгуулахаар болжээ. Нийтдээ 344.2 сая ам.долларын санхүүжилтээр хэрэгжих энэхүү бүтээн байгуулалт нь 2014 онд эхэлж, 2024 онд дуусах учиртай.

Одоогоор Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүд баригдаж, Дамбадаржаа, Дэнжийн 1000 дахь бүтээн байгуулалтын ажил 2019 онд эхэлсэн бол мөн онд Толгойт, Шархадны дэд төвийн ТЭЗҮ нь хийгдсэн билээ.

Тэгвэл Дэд төвүүдэд ямар бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна вэ? Тухайлбал, Баянхошуу дэд төвд Бизнес инкубатор сургалтын төвийн барилга ашиглалтад оржээ. Энэ төвд байх Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв нь иргэдэд нутгийн захиргааны байгууллагын 287, Засгийн газрын харьяа агентлагийн 99, нийт 386 үйлчилгээг хүргэж байгаа. Бизнес инкубатор төв нь Дэд төвд оршин суугчид бизнес эрхлэх, өсч хөгжих болон бизнес эрхлэх экосистемийг бий болгох зорилготой. Ая тухтай хамтын оффисоор хангаж, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэх, гарааны бизнесийг бойжуулах зэрэг үйлчилгээг үзүүлнэ. Нийгмийн энэ мэт үйлчилгээнээс гадна тухайн орчинд инженерийн хангамж, дэд бүтэц шийдэгдсэнээр иргэдэд амьдрах тав тухтай орчин бүрдэж байгаа юм. Сэлбэ дэд төвд л гэхэд Дулааны станц ашиглалтад орсноор ойр орчмын аж ахуйн нэгжүүд төвлөрсөн халаалалттай болсон давуу талууд хэдийнэ гараад байна.

Баянхошуунд л гэхэд дэд төв байгуулсны үрээр, 10 жилийн турш хотхон дотроо уурын зуух галлаж нэг өвөлд хэдэн мянган тонн нүүрс түлж, жилдээ тэрбум төгрөгийн татаас нийслэлийн төсвөөс авдаг байсан 720 өрх төвийн дулаанд холбогдож

Төслийн I үе шат

Баянхошуу	ДЭД ТӨВ	Сэлбэ
162 га	Газрын хэмжээ	156 га
6.5 км	Авто зам	6.8 км
27.9 км	Дулаан шугам	9.97 км
14 ш	УДДТ	15 ш
5 ш	ХТП	3 ш
10.9 км	Цэвэр усны шугам	9.34 км
15 км	Бохир усны шугам	15 км
35/10 кВ	Дэд станц	35/10 кВ
6.3 км	Цахилгааны шугам	3.5 км
2.9 км	Холбооны шугам	5.5 км
4.65 га	Тохижилт	3.01 га
4.7 км	Ногоон байгууламж, ҮХС	2.1 км

Барилга байгууламжууд

- 240 хүүхдийн цэцэрлэг
- Бизнес инкубатор, сургалтын төв
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга
- 20 айлын орон сууцны барилга
- 1000м3 усан сан, насос станц барилга

- Сэлбэ дулааны станц
- Бизнес инкубатор, сургалтын төв
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвийн барилга
- 240 хүүхдийн цэцэрлэг
- 1000м3 усан сан, насос станц барилга

чадсан. Ер нь төлөвлөлт ёсоор бол, нэг шинэ дэд төв 100 мянган хүнд хамаарна гэсэн тооцоотой аж. Хэрвээ зургаан дэд төвийг байгуулж чадвал 600 мянган хүнийг хотын түгжрэлээс холдуулж чадах нь.

Хэдийгээр энэхүү үйл явцыг хотын төвөөс аль болох холдуулах арга мэтээр тайлбарлаж болох ч үнэндээ иргэндээ аливаа хэрэгцээт үйлчилгээ, тэгш боломж нөхцөлийг ойртуулж буй үйл хэрэг гэж ойлговол зохистой. Хүн хотын төв, эсвэл хотын захад амьдарч байгаагаас эс шалтгаалан боломжийг тэгш хүртэх учиртай. Үндсэн хуульд заасанчлан Монгол Улсын иргэн бүр эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны тэнцэл алдагдахаас сэргийлүүлэх эрхтэй. Гэтэл өдгөө хотын захын дүүргүүдэд аж төрөгсөд адил тэгш амьдралын нөхцөлөөр хангагдаж чадахгүй байгаа нь бодит үнэн. Нийслэлийн хүн амын 60 хувь нь нүхэн жорлонтой, халуун усгүй, төвлөрсөн дулаангүй, шороон замтай, сургууль цэцэрлэг дутагдсан, кино театргүй, кофе шопгүй орчинд амьдарсаар л байгаа. Тэгвэл хотын захыг хотын төв ч болгож болно. Гэр хорооллоо цэвэр бохирын шугамтай, халуун дулаантай, зам харгуйтай, нэг цэгийн үйлчилгээ, шинэ цэцэрлэг, Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төвтэй, спорт цогцолбор, цэцэрлэгт хүрээлэнтэй болгох боломж нь Дэд төвүүд юм. Дэд төвүүдийг байгуулснаар Гэр хорооллын газар эргэлтэд орж, дэд бүтцээ дагаад зах зээл тэлж, бие даан хөгжиж, хүн амын суурьшил нягтрал тэндээ өсч нэмэгдэх ч болно.

Бид нийслэл хотоо яндангүй хот болгоно гэсэн том лоозонтой улс. Энэ нь нэг ёсондоо гэр хорооллыг багасгах төлөвлөгөө юм л даа. Гэвч харамсалтай нь одоо хүртэл энэхүү лоозонгоо хэрэгжүүлэх олигтойхон шийдлийг олоогүй л яваа. Засгийн газрын зорилтоор бол гэр хорооллын 200 мянган өрхийн орчин үеийн тохилог орон сууцаар хангах юм гэсэн. Гагцхүү үүний шийдэл нь мөнөөх зургаан цэгт Дэд төв байгуулах ажил байж мэднэ.

Төслийн II үе шат

Дамбадаржаа	ДЭД ТӨВ	Дэнжийн мянга
70.7 га	Газрын хэмжээ	131 га
2.8 км	Авто зам	0.7 км
2.6 км	Дулаан шугам	8.2 км
5 ш	УДДТ	8 ш
2 ш	ХТП	5 ш
2.3 км	Цэвэр усны шугам	8.2 км
3 км	Бохир усны шугам	5.7 км
6.6 км	Цахилгааны шугам	20 км
5.9 км	Холбооны шугам	4.5 км
2.1 км	Үерийн хамгаалалтын суваг	2 км
1.5 км	Хөрсний ус зайлуулах шугам	1.5 км

Барилга байгууламжууд

- 63 мВт Дулааны станц
- 150 хүүхдийн ортой цэцэрлэг
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв

- 93 мВт Дулааны станц
- 240 хүүхдийн ортой цэцэрлэг
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв

Ийм боломж байгааг олж харсан Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ тэрхүү зургаан Дэд төв дээр нэмж, дөрвөн Дэд төв байгуулах чиглэлийг хотын даргад өгсөн. Ямар ч тохиолдолд хот хөгжих ганцхан л гарц байдаг. Дэд бүтэц, инженерийн хувьсгал хийх зам.

Хотын хэт төвлөрлийг задлахын тулд олон төвүүдтэй болж, тэдгээр төвөө төвлөрсөн дулаанд бүрэн холбочихвол яндан алга болно. Яндангүй бол утаагүй болно. Хэрвээ хэт төвлөрсөн, хотын төвдөө бөөгнөрсөн байдлыг арилгаж, дүүрэг бүрт хөгжлийн төв үүсэх юм бол хүн бүр хотын төвийг зорих шаардлагагүй болно. Хотын төв рүү ирэх хөдөлгөөн багасвал түгжрэл багасч таарна. Ийм л логик өнөөдрийн Улаанбаатарт хэрэгтэй байна. Тэгэхгүйгээр одоогийн нийтийн аж ахуйн болон эрчим хүчний сүлжээ ачаалаа даахгүйд хүрсэн. Өндөр өртөгтэй, чанар муутай дэд бүтцээс шалтгаалж, орон сууцны үнэ буухгүй байна. Иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууц хангалтгүй байгаа нь ердөө л тэнгэрт тулсан үнэтэй газар, дэд бүтцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалдаг.

Ирээдүйд өрсөлдөх чадвартай, олон улсын бизнесийн төв, дэлхийн хөгжилтэй орнуудын нийслэл хотуудын жишигт хүрсэн хот байгуулъя гэвэл, ерөөсөө л хотын төвөө олон хэсэг болгож задлах л юм билээ. Өндөр нягтрал, өрсөлдөх чадвартай ажил хэргийн дүүрэг, Дэд төвүүдийг бий болгож чадвал өнөөгийн Улаанбаатар хотын зовлон арилна.

Орчин үе биднээс илүү зохион байгуулалттай, төлөвлөлттэй байхыг шаардаж байна. Ийм үед хотын доторх дэд төвүүд нь тухайн цаг үеийнхээ хамгийн дэвшилтэт шийдэл, технологийг

Төслийн III үе шат

Шархад	ДЭД ТӨВ	Толгойт
210га	Газрын хэмжээ	148.8 га
8.1 км	Авто зам	8.31 км
6.5 км	Дулаан шугам	5.21 км
9 ш	УДДТ	8 ш
5 ш	ХТП	10 ш
8.1 км	Цэвэр усны шугам	5.12 км
4.3 км	Бохир усны шугам	3.8 км
4.47 км	Цахилгааны шугам	22.6 км
2.7 км	Холбооны шугам	7.38 км
1 га	Тохижилт, ногоон байгууламж	1 га
2.1 км	ҮХС	5.9 км

Барилга байгууламжууд

- 240 хүүхдийн ортой цэцэрлэг
- Бизнес инкубатор, сургалтын төв
- 63 айлын орон сууцны барилга
- Олон нийтийн хөгжлийн төв
- 400 хүний суудалтай спорт цогцолбор
- 1000 м3 усан сан
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв
- 240 хүүхдийн ортой цэцэрлэг
- Бизнес инкубатор, сургалтын төв
- Эрүүл мэндийн төв
- Олон нийтийн хөгжлийн төв
- Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв

шингээж, хөгжлийн түвшинг тодорхойлж байх учиртай. Хотын төвдөө бүх шинэ технологийг хэрэгжүүлэх гэх хэрэггүй гэсэн санал. Жишээ татахад, Бээжингийн шинэ Дэд төв болох Сюнаньд 1.3 сая м2 талбайтай газар доорх тээврийн систем баригдаж байна.

Тэгвэл Улаанбаатар хот өдгөө нэгэнт метрополитан хотын зэрэг зиндаанд очжээ. Иймд бүх дулаан, цахилгаан, цэвэр бохир усаа өөрөө шийддэг Дэд төвүүдтэй болж, тэдгээр газарт төрийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж эхэлбэл гэр хорооллын гэх иргэдийн газар эргэлтэд орж, үнэ хүрнэ. Ингэснээр газраа үнэлж, орон сууцанд орох нөхцөлүүд бүрдэнэ. Цаашлаад метрополитан хотын жишгээр дагуул хотын тухай ч асуудал хөндөгдөнө. Нийслэлийн дагуул хотод Багануур, Багахангай, Налайхаас гадна шинээр төлөвлөсөн Эмээлт-Аргалант, Шинэ нисэх онгоцны буудлыг дагаж үүсэх Аэро сити, Майдар хотыг хамруулж байна. Гэтэл яг өнөөдрийн нөхцөлд дагуул хотууд хөгжих бололцоо төдийлөн бүрдээгүй гэж хэлчихэд буруудахгүй. Учир нь эдийн засгийн хувьд асар өндөр зардалтай.

2000 оноос өнөөдрийг хүртэл найман аймгийн хүн амтай тэнцэх хэмжээний иргэн нийслэлд шилжин иржээ. Энэ нөхцөлд нүүн ирэгсдийг дагуул хотууд руу хүчээр хуваарилах боломжгүй. Тэд Улаанбаатар хотын аль нэг булан, тохойд л шингэж байгаа нь нууц биш. Ийм тохиолдолд хамгийн тохиромжтой, цаг тулсан шийдэл нь энд өгүүлсэн Дэд төв хэмээх мэргэн төлөвлөгөө ажгуу.

АРНАУД ХЭКМАНН:

Гэр хорооло дэд бүтцийн шугам сүлжээг цогцоор нь барьж байгуулах хэрэгтэй

"Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн талаар Азийн хөгжлийн банкны хот төлөвлөлтийн багийн ахлах мэргэжилтэн Арнауд Хэкманнтай ярилцлаа.

Монгол Улс АХБ-нд элсээд 30 жил болж байна. Энэ хугацаанд МУ-д хэдий хэмжээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэв, УБ хотод нийт хэдэн төсөл хэрэгжүүлэв?

1997 оноос хойш Азийн хөгжлийн банк (АХБ) ньМУ-д үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш олон салбарт жишээлбэл,эрүүл мэнд, боловсрол, эрчим хүч, тээвэр, хот төлөвлөлт зэрэг секторт хамтарч ажиллаж байна. Энэ утгаараа МУ-ын нийгэм эдийн засгийн салбарт хамтран ажиллаж түншлэлийн жилүүдэд МУ-ын хөгжлийг дэмжиж ирсэн. Хот төлөвлөлтийн чиглэлээр олон төсөл хэрэгжүүлж байгаа, тухайлбал, орон сууц болон орон сууцны зээлийн төслүүд хэрэгжиж Монголын Ипотекийн Корпораци болон орон сууцны систем үүсэх үндэс болсон. Мөн дэд бүтцийн төслүүд байгаа. АХБ нь эхэн үедээ аймгийн төв болон сумын төвүүдийг хөгжүүлэх тал дээр түлхүү ажиллаж байсан. Харин Дэлхийн банкны хувьд Улаанбаатар хотод төвлөрчдавхардлыг үүсгэхгүй байх тал дээр бид анхаарч ажиллаж байсан. Тийм учраас аймгийн төвүүдэд автозам, усан хангамж, ариутгах татуурга болон цэвэрлэх байгууламжзэрэг дэд бүтцийн ажлуудыг хийж байсан. УБ хотын гэр хорооло өргөжин тэлсэн нь хүн амын өссөлт, бохирдол болон байгаль орчны асуудлуудыг дагуулан гарч ирсэн. Иймээс АХБ нь УБ хотын гэр хорооллын тулгамдсан асуудлыг шийдэж хөгжүүлэх цогц төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. АХБ-ны санхүүгийн болон техникийн дэмжлэгийг буцалтгүй тусламж, зээл, техникийн туслалцаа (ТТ)-аар нийлээд 423.24 сая ам.доллараар хангаж, 155 сая ам.долларын зээл, 53 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хамтын санхүүжилтийг дайчлаад байна. Хотын салбарт АХБ-ны 14 орчим төсөл (Зээл, буцалтгүй тусламж) Монгол Улсад хэрэгжсэн буюу хэрэгжиж байгаа (мөн 20 орчим техникийн туслалцаа) байна. Эдгээр төслийн зургаа нь Улаанбаатар хотод хэрэгжиж байна.

Нийтлэлч
О.Эрдэнэчимэг

АХБ-аас ГХХХОДХ-д анх хөрөнгө оруулалт хийхдээ яагаад урт хугацааны олон транш хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээл олгохоор шийдсэн бэ?

Шалтгаан нь маш энгийн. Дэд бүтэц байхгүй бол гэр хорооллын тогтвортой хөгжил гэж байхгүй, хүн амын нэгдэл үүсэхгүй, хот болон хотын захын гэр хорооллын ялгаа асар их гарч байгаль орчны болон бохирдлын асуудлуудыг дагуулж нийгмийн бухимдлыг үүсгэнэ. Одоогийн байгаа дүр зураг бол үйлчилгээ болон албан байгууллагууд хотын төвдөө төвлөрч ажлын байруудыг үүсгэсэн байна, захын хорооллуудад үйлчилгээ байхгүй байна. Иймээс хотын төвд төвлөрөл үүсч захын хорооллоор үйлчилгээ болон боломжууд дутагдаж байна. Боломж болон гэр хорооллын хөгжлийг дэмжихийн тулд тэнд бүрэн хэмжээний дэд бүтцийг байгуулах хэрэгтэй. Усан хангамж, төвлөрсөн дулаан, автозам, цахилгаан холбоо болон нийгмийн барилга байгууламж зэрэг хотод байх дэд бүтэц, барилга байгууламжууд шаардлагатай. Эдгээрийг хийхгүй бол хувийг хэвшлүүдийн хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй, иргэд өөрийн газрыг хөгжүүлж хөрөнгө оруулах боломж бүрдэхгүй. Дэд бүтэцгүйгээр хотын төлөвлөлт явахгүй. Хот руу шилжих хөдөлгөөн зогслоо ч гэсэн гэр хорооолд цаашдаа байгалийн хуулиар хүн ам өсч нягтарших тул асуудлууд даган нэмэгдэх нь тодорхой. Гэр хорооллын цаашдын хөгжил, иргэдийн эрүүл мэнд бүгд дэд бүтцээс хамааралтай. Бид төвлөрлийг сааруулах, тусдаа бие даасан хувилбаруудыг бодолцож үзсэн гэвч энэ нь МУ-ын цаг агаарын нөхцөл байдалд тохирохгүй байсан. Иймээс одоогийн байдлаар үүсч бий болсон төвүүдийг цааш нь хөгжүүлж хотын хөгжлийн тэнцвэртэй байдлыг тогтоож хотын 1 том төвтэй түүнийг тойрсон ажил, үйлчилгээ авч болох дэд төвүүд бий болгох зарчим дээр тулгуурлан ажиллаж байна.

Европын Хөрөнгө оруулалтын банктай хамтран санхүүжүүлж байгаа гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр нь гэр хорооолд зургаан шинэ дэд төвийг бий болгохын тулд гэр хорооолд үндсэн дэд бүтэц, нийгэм, эдийн засгийн нэн тэргүүнд тавигдах байгууламжууд болон нийтийн талбайг барьж байгуулаж байна. Дэд төвүүдэд төрийн болон нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулснаар 500,000 орчим оршин суугчдад ашиг тус хүртэх болно.

Нэгдүгээр үе шатны хүрээнд дэд төвүүдийг хөгжүүлээд зогсохгүй УСУГ-ын цэвэр болон бохир усны үйлчилгээний чадавхи, дижитал хяналтын системийг сайжруулж, хотын төвийн нэн тэргүүнд тавигдах цэвэр, бохир усны шугам хоолойг сольж, одоо байгаа цэвэрлэх байгууламжийг шинэчилсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тэгэхээр та хөтөлбөрийн хамрах хүрээ маш өргөн хүрээтэй байгааг харж байгаа байхаа.

ГХХХОДХ-ийн хүрээнд дэд төвүүдийг бүтээн байгуулах нь гол ажил байгаа, та бүхэн дэд төвийг юу гэж тодорхойлж байгаа вэ?

Өмнө хэлсэнчлэн дэд төв нь хотын хөгжлийн тэнцвэрийг хангах ёстой. Дэд төв нь ажил, үйлчилгээ үзүүлэх, ажлын байр бий болгох, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх шийдлүүдийг иргэдэд хотын төв оролгүйгээр авах боломжоор хангана. Хотын төвөөс авч болох бүх л үйлчилгээ зэргийг дэд төв нь нэгтгэж хангадаг байна. Мөн тухайн дэд төвдөө орон суугаар хангах боломжийг олгодог байна. Зөвхөн тухайн дэд төвд амьдарч буй иргэд биш эргэн тойрны оршин суугчдад хүртэл төрийн болон бусад үйлчилгээг хүргэдэг эдийн засгийн боломжийг олгодог онцлогтой. Өөрөөр хэлбэл дэд төв нь бүх боломжит үйлчилгээ болох нийтийн танхим талбай, спорт төв, эдийн засгийн боломжууд, автозам, тээврийн үйлчилгээ, соёлын үйлчилгээ гэх мэт бүхий л үйлчилгээгээр хангадаг байна. Мэдээж хотын төвийн үйлчилгээний зэрэгтэй адилтгахад хэцүү ч тухайн орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.

Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалт тод харагдаж байна. Төслийн хүрээнд хэдэн дэд төв байгуулах вэ? Одоогоор хэдий хугацаанд дэд төвүүдийг барина гэж харж байгаа вэ?

Гэр хорооллын дэд төв болох дэд бүтцийн байгууламж, нийгмийн барилга байгууламж буюу цэцэрлэг, бизнес инкубатор зэргээс бүрдсэн дэд төв байгуулах ажлыг эхний үе шат гэж харж үзэж болно. Хувийн сектор, иргэд олон нийтийн оролцоо, төр засгийн газрын оролцоо нь эдгээр дэд төвүүдийг нь цааш нь хөгжүүлж явуулахад чухал нөлөөтэй юм. Дэд бүтэц байгаа тул эдгээрийг хийх боломжтой. Улаанбаатар хотод дэд бүтцийн хомсдол байгаа боловч дэд төвүүдэд барьж байгуулсан дэд бүтэц нь бусад хөрөнгө оруулалтыг татах болно. Хотын төвийн дэд бүтцийн зураг төсөл, шийдлийг 500 000 хүн амд зориулж хийсэн. Гэтэл одоо энэ тоо 1.4 сая буюу 3 дахин өссөн. Иймд дэд төвүүд нь бусад хэсгийн үйл ажиллагааг өргөжүүлж, сонирхлыг татаж байгаа юм. Энэ бол эхний алхам билээ. Үүнтэй зэрэгцэн яваа өөр нэг зүйл бол эдгээр дэд бүтцээр дамжуулан эко дүүрэг шийдэл, блок девелопмент, төлбөрийн чадварт нийцсэн орон суугаар мөн барьж байгуулах юм. Эхлээд дэд бүтцийг байгуулсны дараа орон суугаар дараагийн алхам руу шилжих юм. Мөн бид НЗДТГ-тай тэдгээрийн засаг захиргааны нэгжүүдийн төвлөрлийг дэд төвүүд рүү шилжүүлж, төвлөрлийг сааруулах талаар хэлэлцэж байна. Түүнчлэн, хувийн секторыг дэд төвүүдийн хөгжилд татан оруулах бид цаашид ажиллана. Ийнхүү дэд төвийг байгуулах нь нэг өдрийн ажил биш, хугацаа мэдээж шаардана. Монгол улс, Улаанбаатар хотод ийм төслийг анх удаа хэрэгжүүлж байгаа гэдгийг та бүхэнд дахин сануулахыг хүсч байна. Дэд төвүүдэд бүх үйлчилгээг жигд үзүүлдэг болох талаар НЗДТГ-тай урт удаан хугацаанд хамтарч ажиллана. Энэ нь амар хялбар процесс биш. Харин урт хугацааны тогтвортой байдлаар хийгдэх ажил юм. Иймд дэд төв гэдэг нь анхны алхам юм. НЗДТГ-тай хамтран ажилласны үр дүнд төслийн 1-р үе шат дуусч байна. Монгол улс, Улаанбаатар хотод анх удаа хийгдэж байгаа төсөл тул хүчин чармайлт их орсон. Мөн бид ЕХОБ-тай хамтарч ажилладаг. ЕХОБ томоохон хөрөнгө оруулалт, санхүүжилт, техник туслалцаа үзүүлсний хүчинд энэхүү том төслийн 1-р үе шат амжилттай хэрэгжиж дуусч байна.

Улаанбаатар хотод дэд төвүүдийг байгуулснаар Улаанбаатар хотын хэт их төвлөрөлтийг сааруулахад ямар хувь нэмэр оруулах вэ?

Өмнө нь дурдаж байсанчлан хотын төвийн төвлөрлийг бууруулах гол шийдлийн нэг нь гэр хорооллын дэд төв юм. Засгийн газар, төр захиргааны зүгээс дэд төвийн хөгжил нь хотын төвийн төвлөрлийг бууруулахад ямар хувь нэмэртэй талаар асууж, тодруулж байсан. Дэд төвийн хөгжил нь Нийслэл хотын төвлөрлийг бууруулах стратеги төлөвлөгөөтэй уялдаж байгаа. Энэ нь тун сайн юм. Ингэснээр төр захиргааны дэмжлэгийг авч, дэд төвийг илүү идэвхтэй байлгах болон хувийн салбар, иргэдийн оролцоог авах боломжтой болох юм. Дэд бүтцийн бүтээн байгуулалтаар дамжуулан дэд төвийг хөгжүүлж байгаа. УБХГХХХДХ төслийн дэд бүтцийг ашиглах замаар хөгжлийн бусад хамтрагчидтай хамтарч байна. Жишээ дурдахад Баянхошуу дэд төв дэх Бизнес инкубатор төвд Нийслэлийн 300 гаруй төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Баянхошууны иргэд төрийн үйлчилгээг нутаг дэвсгэрээсээ авах боломжтой болж байгаа юм. Ингэснээр иргэдийн шилжих хөдөлгөөн, замын хөдөлгөөнд эерэгээр нөлөөлж байна. Иймд дэд төвийн хөгжил нь хотын төвийн төвлөрлийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулахад шууд нөлөөтэй юм. Энэ төсөл нь анхны алхам боловч бид цаашаагаа сайн явах ёстой. Дэд төвүүдийг хөгжүүлснээр хотын төвийн хөгжлийн балансыг тэнцүүлэх болно.

Хөтөлбөрийн хүрээнд шийдэгдэж байгаа дэд төвүүдийн дэд бүтэц сайн шийдэгдэж байгаа. Тийм учраас орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх үү гэж асуумаар байна.

Сайхан асуулт байна. Дэд бүтэц байгуулах нь өртөг ихтэй. Гэр хорооллыг бүхэлд нь дэд бүтцээр хангах нь боломжгүй. Иймд УБХГХХХОДХ төслийн урт хугацааны бодлого нь цаашид орон нутгийн хөгжлийн боломж, бололцоо хаана илүү их байна тэнд дэд бүтцийг байгуулах юм. Тэгснээр дэд бүтэцтэй газарт төвлөрлийг бий болгож, хүмүүсийг татах, улмаар дэд бүтэцгүй газар дахь төвлөрлийг бууруулах юм. Гэр хорооллын одоогийн нөхцөл бол хотын төвтэй харьцуулашгүй байгаа. Гэр хорооолод нүхэн жорлон, нүүрс галлагаатай зуух хэрэглэж байна. Ийм нөхцөл байдал нь жижиг суурин газар, хөдөө орон нутагт байж болох зүйл. Харин хотын хувьд ийм байж болохгүй. Гэр хорооолод дэд бүтцийг байгуулснаар дэд бүтэц нь хүмүүсийн анхаарлыг татаж, дэд бүтэцгүй хэсгийн ачаалал буурах юм. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хэрэгцээ шаардлага маш их байгаа. Маш олон хүмүүс 10 км зайд нүүж, амьдрах сонирхолгүй байдаг. Хүмүүс одоо амьдарч буй газартайгаа ойрхон орон сууц, нийтийн байранд амьдрах сонирхолтой байдаг. Гэр хорооллын дэд бүтцийн хөгжил нь төлбөрийн чадварт нийцсэн орон сууц барихад дөхөм үзүүлнэ. Мөн төвлөрлийг бий болгох, бусад хэсгээс ирж буй хүмүүсийн сонирхол, анхаарлыг татах зорилгоор дэд төвүүдэд 10 000 орлогод нийцсэн ногоон орон сууц барих төслийг хэрэгжүүлж байна. Гэр хорооллын ихэнх хүмүүс өөрсдийн газраа эзэмшдэг. Харин энэ эзэмшил газарт маш олон хүмүүс амьдарч байдаг. Зарим тохиолдолд нэг хашаанд 4 өрх амьдарч байгаа. Нягтралыг тодотгох үүднээс үүнийг хэлж байгаа юм. Эдгээр өрхүүдэд орон сууцанд нүүж, амьдрах хэрэгцээ шаардлага байгаа. Газар эзэмшигч иргэд өөрсдийн өмчлөлийн газраа орон сууцаар солилцох боломжтой. Харин эзэмших эрхгүй иргэдийн хувьд энэ их хүндрэлтэй. Дэд төвийг хөгжүүлснээр орон сууцжуулах боломжтой.Ингэснээр гэр хорооллын иргэд орон сууцанд орох боломжтой болно.

Хөтөлбөр хэрэгжснээр төслийн үр өгөөжийг Улаанбаатар хотын хүн амын хэдэн хувь нь хүртэнэ гэж тооцоолж байгаа вэ?

Энэ асуулт хэд хэдэн өнцгийг агуулж байна. Хэдэн хүн үр шим хүртэх вэ гэж та асууж байна. Төслийн шууд бус нөлөөлөл нь нийслэлийн бүх хүн амд нөлөөлнө. Яагаад гэвэл дэд бүтцийн төвлөрсөн шугам сүлжээг дэд төв хүртэл тэлж, өргөжүүлснээр засаг захиргаа, бизнесийн байгууллага төвлөрсөн дулаан хангамжтай холбогдох, гэр хорооллын иргэд орон сууцанд амьдрах боломж нөхцөл бүрдэх юм. Ингэснээр агаар бохирдуулагч халаалтын зуухнуудыг буулгаж, агаарын бохирдлыг бууруулахад дорвитой нөлөө үзүүлнэ. Төвлөрсөн системтэй холбогдсноор хэдэн хүн шууд үр нөлөө авах тоог би танд дараа нь гаргаж өгч болно. Ингэж бодохоор хотын бүх иргэд төслийн үр шимийг хүртэж байгаа юм. Төвлөрлийг сааруулж, замын түгжрэлийг бууруулах нь төслийн үр шимийн нэг хэсэг юм. Дэд төвтэй ойролцоо амьдарч буй тодорхой тооны хүмүүс төслийн шууд үр шим хүртэгчид юм. Нэг дэд төвийн үйлчилгээнд дунджаар 100 мянган хүн хамрагдана гэсэн тооцоо бий. Тиймээс 6 дэд төв нь нийт 600,000 орчим хүнд ашиг тус хүртэх болно. Эцэст нь 15,000 орчим хүн дэд төвийн хилийн дотор амьдарч байгаа бөгөөд дэд төвийн дэд бүтцээс шууд ашиг хүртэх болно. Бидний зорилго бол энэ тоог гурав дахин нэмэгдүүлж, төвлөрлийг нэмэгдүүлэх явдал юм. Ирээдүйд дэд бүтэц, орон сууцны бүтээн байгуулалтаас шууд ашиг хүртэх 500 мянга орчим хүн дэд төв бүрт бий. Бас нэг зүйлийг нэмж хэлье.

ГХХХОДХ төслийн бүрэлдэхүүн хэсэг болон АХБ-ны санхүүжилтээр УБ болон Монгол улсын хот төлөвлөлтийн чиглэлээр хэрэгжиж буй бусад төслүүдийн талаар ярина уу.

АХБ-наас Монголд олон төрлийн төсөл хэрэгжиж байна. ГХХХОДХ-г дэмжих үүднээс залуучуудын оролцоог дэмжих техник туслалцааны төсөл (ТТ), гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр, ЖДҮ-ийг хөгжүүлэх ТТ, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн туслалцааны төсөл хэрэгжиж байна. Тэдгээр томоохон төслүүдийн нэг бол дэд төвүүдэд хямд өртөгтэй, ногоон орон сууц барьж, дэмжих зорилготой Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууцны төсөл юм. Энэ бол 500,000 сая ам.долларын өртөгтэй асар том төсөл бөгөөд нийт хөрөнгө оруулалтын гуравны хоёрыг хувийн хэвшил гаргана. Аймгуудын усан хангамжийг чиглэлээр дэмжих зорилготой төслүүд хэрэгжиж байна. Аймгуудын бүсчилсэн хөгжлийг дэмжих, ногоон хөдөө аж ахуйн бизнес

төслийг Барилгын яамтай хамтран 10 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна. Төсөл нь махны экспортыг дэмжих зорилгоор ажлын байр бий болгох, малын чанарыг дэмжих аймаг, сумдын хөгжлийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Төслийн 2-р үе шат хэзээ эхэлсэн, ахиц дэвшил ямар байна вэ?

2-р хэсэг 2019 онд эхэлсэн бөгөөд дараагийн хоёр жилд хэрэгжинэ. Нарийвчилсан зураг төсөл бараг дууссан, нүүлгэн шилжүүлэлт ч дуусч байна. Дамбадаржаа, Дэнжийн 1000-д дэд төвүүд барина. 2-р хэсгийг хүрээнд бид тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Тухайлбал, Баянхошуунд спорт цогцолбор барих, Сэлбэ дэд төвд хийх бусад ажлууд. Үе шат 1-ийн хүрээнд зөвхөн дэд төвүүдийг хөгжүүлээд зогсохгүй УСУГ-н чадавхийг сайжруулж, усны үйлчилгээний системийн хяналт, бохир ус зайлуулах системийг байгуулсан гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Бүх дэд төвүүд холбогдсон байх ёстой бөгөөд тэдгээрийг холбох ажил хийгдэж байна.

ГХХХОДХТ-н хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгарж байна вэ?

Ийм үлэмж хэмжээний төсөл гэр хорооолд анх удаа хэрэгжиж байгаа учраас манай төсөл онцгой төсөл юм. Өмнө нь гэр хорооолд ус түгээх байр барих төсөл хэрэгжиж, усны шугамын өргөтгөл хийгдэж байсан. ГХХХОДХ нь НЗДТГ-ын агентлагуудыг чадавхжуулах, НЗДТГ болон ТХН-н хоорондын хамтын ажиллагааг дэмжих, төслийг нийслэлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх, олон нийттэй зөвлөлдөх, нүүлгэн шилжүүлэх зэрэг маш олон төрлийн ажлыг хамрах бөгөөд ийм төрлийн ажил ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт шаардаг. Тухайлбал, зам тавих нь иргэдийн газарт маш их нөлөө үзүүлдэг. Тухайлбал, талбар газар нөлөөлөлд өртөх, хөрөнгийн үнэлгээ хийх, гомдол хүлээх, гомдлыг барагдуулах ажлууд хийгдэнэ. Бид хэдийгээр бэрхшээл хүндрэл учирч байсан ч монгол улсын үе үеийн засгийн газар, НЗДТГ бидэнд тасралтгүй дэмжлэг, тусламж үзүүлж байсан нь төслийн зорилго, цар хүрээ, шаардлага, үр өгөөжийг ухамсарлаж байгаатай холбоотой юм. Энэ тусламж дэмжлэгт бид маш их талархаж байна.

АХБ болон Монгол улсын харилцаа цаашид ямар ямар талбаруудад өргөжих боломжтой гэж та харж байна вэ?

Мэдээж хамтран ажиллах олон талбарууд бий. Энэ зөвхөн Монгол улс учраас биш юм. Ямар ч улс оронд Засгийн газар болон АХБ гэх мэт бусад түншлэгч нарын анхаарах ёстой асуудлууд байдаг. Нэгдүгээрт бид ногоон ажлыг дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх, улсын хөгжлийг баланслуулахын тулд ногоон эдийн засгийн сэргэлтэнданхаарах хэрэгтэй гэж бодож байна. Одоогоор бид улсын төв хэсэг, ялангуяа маш олон асуудалтай, хот болон хөдөөг тусгаарласан Улаанбаатар хотод анхаарлаа хандуулан ажиллаж байна. Бидэнэ төслөөр болон бусад төслөөр дамжуулан Монголын засгийн газрыг илүү дээр институц бий болгох, Монгол улсыг тэнцвэртэйгээр хөгжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэхэх үүсвэртэй болох, аймгийн төвүүдийн хөгжлийг дэмжих, ингэснээр эдийн засгийн боломжуудыг нэмэгдүүлэх (эс бөгөөс шилжилт хөдөлгөөн үргэлжлэх болно), Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах чиглэлээр дэмжин ажиллахыг хичээж байна. Бид засгийн газартай эрчим хүч, ногоон эрчим хүч, нөхөн сэргээгдэх эрчим хүч, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах, ялангуяа хувийн нийтийн тээврийн систем, зам сайжруулах, боловсрол болон бусад секторуудад хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх болно.

Нийтлэлч
С.Шийлэгтөмөр

2009
Гэр хорооло́лд Дэд төвүүдийг барьж байгуулах суурь судалгаануудыг эхлүүлэв.

2012
“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн ТЭЗҮ-ийг баталлаа.

2013.12.09
Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцийг баталсан.

2014.05.23
“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг санхүүжүүлэх санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлав.

2014
НИТХ-ын 108 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын А/551 тоот захирамжаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулж, бүтэц, орон тоог 11 ажилтантай баталсан. Мөн НИТХ-ын Тэргүүлэгчдийн 107 тоот тогтоолоор төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг батлав.

2015.06.05
Төсөлд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг Франц улсын “Эжис интернэйшнл” компанитай байгуулсан.

2015.07
Баянхошуу, Сэлбэ дэд төвийн иргэд, олон нийтийн оролцоог хангах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гэрээг НҮБ-ын Хабитат олон улсын байгууллагатай байгуулав.

2016.12.21
Баянхошуу дэд төвд ариутгах татуургын 1-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн (3ш) хоолой бүхий ариутгах татуургын шугамыг ашиглалтад оруулав.

2017.02
Зөвлөх баг хөтөлбөрийн 2-р үе шатын ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээлгэн өгөв. Энэхүү ТЭЗҮ-ийн дагуу төслийн 2-р үе шатны төслийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг эхлүүлсэн.

2017.03.04
Баянхошуу, Сэлбэ дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг иргэдэд танилцуулах, зөвлөлдөх уулзалтыг 30 удаа зохион байгуулж, иргэдийг мэдээлэлээр хангалаа.

ДЭД ТӨВ: Өнгөрснөөс өнөөдрийг хүртэл...



2017.07
Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд дэх нэгж талбар бүрийн инженерийн байгууламж болон айл өрхийн нийгэм, эдийн засгийн суурь судалгааг авч мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэв. Газар зүйн мэдээллийн бааз үүсгэх ажлын хүрээнд Дэд төв тус бүрээр 22 төрлийн газрын зураг гаргасан.

2017.11.30
Азийн хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүрэг, амлалтуудыг биелүүлэх хүрээнд байгаль орчны хөндлөнгийн хяналтын зөвлөхөөр "Сошио энвайронментал сервис" ХХК шалгаран гэрээ байгууллаа.

2018.11.18
Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар Ус сувгийн удирдах газрын үйл ажиллагааг сайжруулах барилга байгууламжийг ашиглалтад оруулав.

2018.12.05
Сэлбэ дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон хамгаалалтын хайсны угсралт суурилуулалтын ажил дуусч хүлээн авсан.

2018.12
Зөвлөх баг үүргийн дагуу гэрээт ажлуудыг гүйцэтгэн эцсийн тайлангаа хүлээлгэн өгснөөр гэрээ дуусгавар болсон.

2017.10.24
Сэлбэ дэд төвд ариутгах татуургын өөрийн урсгалтай зөөлөн ширмэн хоолой ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлын дуусгаж ашиглалтад оруулав.

2017.12.28
Баянхошууны дэд төвд ариутгах татуургын 2-р хэсгийн өөрийн урсгалтай зөөлөн ширмэн хоолой (3ш) бүхий ариутгах татуургын шугамыг ашиглалтад хүлээн авлаа.

2018.11.19
Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил дуусч, ашиглалтад оруулаа.

2018.12.11
Баянхошуу дэд төвд 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлыг бүрэн дуусгаж, ашиглагч байгууллага болох нийслэлийн Боловсролын газарт иж бүрэн тавилга, тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгөв.

2019.01.17
Сэлбэ дэд төвд барих 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гэрээг "Цаст констракшн" ХХК-тай байгуулав.

2019.01.17
Сэлбэ дэд төвд барих мэргэжил сургалт, үйлдвэрийн төв, бизнес инкубатор төвийн барилга угсралтын ажлын гэрээг "Бридж констракшн" ХХК, "Монхас" ХХК нарын түншлэлтэй байгуулав.

2019.01.21
Сэлбэ дэд төвд төлөвлөсөн авто замын борооны ус зайлуулах шугамыг хөрсний усны түвшинг доошлуулах шугам болгох өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах, хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг "Гидродизайн инноваци" ХХК-тай байгуулав.

2019.03.26
Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд мэдээлэл технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг "Ай Ти Зон" ХХК-тай байгуулсан.

2019.03.26
Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд сургалтын төвийн тавилга нийлүүлэх гэрээг "Профешнал сивил инженеринг констракшн" ХХК-тай байгуулав.

2019.01.21
Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг шинэчлэх, зураг төсөл боловсруулах, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг "Усны эрчим" ХХК-тай байгууллаа.

2019.01.29
Орлогод нийцсэн орон сууцны загвар төслийн зураг боловсруулах хяналтыг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг "Аркетайп Монголиа" ХХК-тай байгууллаа.

2019.02.28
Сэлбэ дэд төвийн үерийн далан дагуух тохижилтын ажил хийх гэрээг "Бодь пропертийз" ХХК-тай байгууллаа.

2019.03.26
Баянхошуу дэд төв дэх бизнес инкубатор, мэргэжлийн сургалтын төвд үсчин болон оёдолчны тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг "Декора" ХХК-тай байгууллаа.

2019.06.21
Баянхошуу дэд төвд бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгсөн.

2021 оны IV улиралд багтаан Баянхошуу дэд төвд баригдаж буй бүрэн цутгамал хийцлэл бүхий төвийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон Орлогод нийцсэн 20 айлын орон сууцны загвар төслийг бүрэн дуусгаж газрын эздэд байрны түлхүүрийг нь олгохоор ажиллаж байна.

2019.07.16
Улаанбаатар хотын Орос 14-р сургууль орчмын барилга байгууламжийн бохирын татуургын гол цуглуулах шугамын барилга угсралтын ажил дуусч, ашиглалтад оруулсан.

2019.07.24
Баянхошуу дэд төвийн цэвэр бохир ус, халуун ус болон дулааны шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, угсралт суурилуулалт болон нийлүүлэлтийн ажлын гэрээг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр "Одкон Холдинг" ХХК, "Улаанбаатар барилга" ХХК-ийн түншлэлтэй байгууллаа.

2019.09.11
Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанаар хангах дулааны магистраль шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил дуусч, ашиглалтад оруулсан.

2019.12.06
Баянхошуу дэд төвд орлогод нийцсэн орон сууц ба хот шинэчлэлтийн төслийн туршилтын загвар барилга барих ажил, 20 айлын орон сууц барих тендерийг нээж, үнэлгээ хийж байна.

2019.07.22
Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилга болон аэротанкийн бетон хийцийн шинэчлэлтийн ажил дуусч, ашиглалтад оруулав.

2019.08.02
Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын суваг дагуух талбайн тохижилтын ажлын гэрээг "Дүүрэн Трейд" ХХК, "Байгууламж" ХХК-ийн түншлэлтэй байгуулав.

2019.08.20
Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын гэрээг "Монгол менежмент төв" ХХК, "Улаанбаатар менежмент" ХХК-ийн түншлэлтэй байгууллаа.

2019.10.21
Дэд төвийн болон Улаанбаатар хотын цэвэр усны нөөцийг нэмэгдүүлэх, цагираг сүлжээ бий болгох ажлын хүрээнд Сэлбэ болон Баянхошуу дэд төвүүдэд 1000м3 багтаамжтай усан сан, насос станцын хамт 2019, 2020 онуудад тус тус ашиглалтад оруулав.

2019.12.20
БНСУ-ын “Ханкук инженеринг консалтантс” ХХК, туслан гүйцэтгэгч “Сивил инженеринг консалтинг” ХХК-тай хамтран ажиллах зөвлөх үйлчилгээний гэрээ байгууллаа.”Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төсөл 1”-ийн хүрээнд нийслэлийн ХАА-ны газраас Хотын үндсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, менежментийг сайжруулах болон эрх зүйн шинэчлэлийг дэмжих зөвлөх үйлчилгээний гэрээг, чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалтын аргаар шалгаруулсан.

2020.01.31
Ажлын байран дээрх дадлагажуулагч багш бэлтгэх сургалтад хамрагдан амжилттай төгссөн сурагчид сертификатаа гардан авлаа. Гэрчилгээжсэн болон мэргэшүүлэх сургалт төгссөн иргэдийг гэрээт гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд ажлын байранд зуучлах юм.

2020.03.13
“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 1-р үе (Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд) болон 2-р үе шатны (Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвүүд) барилга угсралтын ажлын явц, төслийн хүрээнд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрийн төслийн талаар төслийн зохицуулагч Д.Авирмэд нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын гишүүдэд төслийн явцыг танилцууллаа. Зөвлөлийн хурлаар тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, холбогдох хүмүүст ажлын хэсэг байгуулан асуудлыг шуурхай шийдвэрлэх үүрэг өглөө.

2020.03.25
Баянхошуу дэд төвд “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв” үүд хаалгаа нээлээ. Ингэснээр иргэд нийслэлийн нутгийн захиргааны долоон байгууллагын 198 үйлчилгээг нэг дороос авах боломжтой болов. Мөн Баянхошуу дэд төв Хүүхдийн номын сантай боллоо. Дэд төвийн Хүүхдийн номын санд нээлгэсэн картаар Нацагдоржийн номын сангаар ч үйлчлүүлэх боломжтой.

2020.03.26
Баянхошуу, Сэлбэ дэд төвийн инженерийн шугам сүлжээ болон нийгмийн байгууламжийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртсөн зорилтот бүлгийн болон өрхийн бизнес эрхлэгч өрхүүдийн амьжиргааг дэмжих хоёр үе шаттай төсөл хэрэгжүүл 96 өрхөд дэмжлэг үзүүллээ. Төслийн үр дүнд нийт 74 иргэн мэргэжлийн болон жижиг бизнес эрхлэх сургалтад хамрагдаж, 65 өрх найман төрлийн өрхийн бизнес хөгжүүлж байна.

2020.04.07
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн хүрээнд гэр хорооолд хийж буй инженерийн дэд бүтэц болон нийгмийн бүтээн байгуулалтын ажлуудтай танилцлаа.

2020.04.24
Баянхошуу дэд төвд Гал унтраах, аврах шинэ анги барих гэрээ байгууллаа. Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд байгуулсан “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн долоодугаар хороо, нийслэлийн Онцгой байдлын газрын эзэмшиж байгаа газарт “Спорт цогцолбор”, Гал түймэр унтраах, аврах ангийн барилгыг барьж хүлээлгэн өгөх зорилгоор төслийн захирал бөгөөд нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалан, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга Ж.Чүлтэмсүрэн нар хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.

2020.05.22
“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Шархад дэд төвийн Цайз эко таун доторх ус хангамжийн болон ариутгах татуургын салбар шугамын барилга угсралтын ажил гүйцэтгэх тендерт “ЧММ” ХХК болон “Шандонг донгхонг индастри пайп” компанийн түншлэл шалгарлаа. Ажил гүйцэтгэлийн гэрээнд түншлэлийн эрх бүхий төлөөлөгчид болон Төслийн зохицуулагч нар гарын үсэг зурж хамтран ажиллахаар болов.

2020.07.07
Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтнүүд газар чөлөөлөлтөд хамрагдсан 112 өрхөд Дамбадаржаа дэд төвд хийгдэх бүтээн байгуулалтын танилцуулга, АХБ-ны хамгааллын бодлого, нөхөн олговор, газрын үнэлгээний захирамж болон үйл ажиллагааны дараалуудыг танилцуулаа.

2020.07.21
Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар төслийн Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлуудтай танилцлаа. Тэрээр *“Төслийн хүрээнд гэр хорооолд цэвэр ус, дулаан, бохир ус гээд дэд бүтцийн ажлууд түүнийг дагасан нийгмийн барилга байгууламжуудын хамт бий болгож байна. Ингэснээр хот зургаан шинэ Дэд төвтэй болж төвлөрөл саарах, агаар хөрсний бохирдол бууруулах нөхцөл бүрдэж иргэдийн амьдрах орчин сайжрах гэх мэт олон давуу талтай эдгээр ажлыг яамны зүгээс дэмжин ажиллах болно”* гэв.

2020.08.19
Төсөл хэрэгжүүлэх нэгж, Германы хамтын ажиллагааны GIZ-ын Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөр хамтран Баянхошуу дэд төвд барьсан Бизнес инкубатор сургалтын төвийг түшиглэн бичил, жижиг дунд бизнесүүдийг дэмжих, харилцан туршлага солилцох чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

2020.05.15
Европын холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газрын Элчин Сайд ноён Траян Лауренцю Христеа болон АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгч ноён Павит Рамачандран нар Баянхошуу дэд төвд ажиллалаа. Төслийн зохицуулагч Д.Авирмэд Баянхошуу дэд төвд барьж ашиглалтад оруулсан Бизнес инкубатор төвийн байранд хүлээн авч төслийн зорилго, үр дүнгийн талаар мэдээлэл өгсөн бол ерөнхий инженер Г.Жанлавцогзол төслийн хүрээнд хийж байгаа ажлуудаа танилцуулсан юм.

2020.05.30
АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Баянхошуу дэд төвийн “Бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төв” нээгдлээ. Ингэснээр Баянхошуу орчимд амьдарч буй 250 мянга орчим иргэд нийгмийн дэд бүтцээр хангагдсан орчинд сурч боловсрох, бизнес эрхлэгчид хөдөлмөр эрхлэх орчин нөхцөлөөр хангагдаж байна.

2020.08.31
Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн ажлыг эхлүүллээ. Инженерийн дэд бүтцийг бий болгосноор Хан-Уул дүүргийн 10-р хороо Морингийн даваа орчим шинэ суурьшлын бүс бий болж 10 мянган айлын орон сууц барих боломжтой болох юм. Бүтээн байгуулалтын ажил 2011.11.26-ны байдлаар 50 хувьтай яваа бөгөөд энэ хүрээнд 1000м3 усан сан, Бохир усны насос станц 2 иж бүрдэл, 10кВ-ын хуваарилах байгууламж 1 иж бүрдэл, 10 кВ-ын 29876м кабель шугам, Ариутгах татуургын 4200 м шугам, Цэвэр усны 11172м шугам, Холбооны 4120м /4+0/ сувагчлалын ажил хийгдэнэ.

2020.09.14
Сэлбэ дэд төвд 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажил дуусаж нийслэл, дүүрэгт хүлээлгэн өглөө. 280-р цэцэрлэгийн барилга нь цэцэрлэгийн гадаа ногоон орчин, тоглоомын талбайтайгаас гадна иж бүрэн тохижуулсан гэдгээрээ онцлогтой. Мөн гэр хороолол дунд барьсан томоохон хэмжээний цэцэрлэг юм.

2020.09.29
Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүллээ. Толгойт дэд төвд 17.26 км цэвэр усны шугам, 8.6 км ариутгах татуургын шугам, 5.78 км дулаан хангамжийн шугам сүлжээ, 14 км урт цахилгаан холбооны шугам сүлжээ, 7.69 км авто зам, 2.74 га газарт цэцэрлэгт хүрээлэн, 240 хүүхдийн цэцэрлэг, олон нийтийн хөгжлийн төв, сургалтын төв, эрүүл мэндийн төв зэрэг инженерийн дэд бүтцийн болон нийгмийн барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг хийхээр төлөвлөсөн.

2021.02.09
Баянхошуу дэд төвд 2 дугаар ээлжийн 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг "Цаст Констракшн" ХХК-тэй 2021 оны 02 дугаар сарын 09-ны өдөр байгуулав.

2021.04.08
Толгойт, Шархад дэд төвийн авто зам, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, холбооны худаг сувагчлалын нарийвчилсан зураг төслийн ажлыг боловсруулж байгаа ВАПКОС зөвлөх багтай ажлын явцын талаар хуралдаж, ажлуудыг эхлүүлэх, түргэвчлэх шийдвэр гаргалаа.

2020.09.28
Сэлбэ дэд төвд гэр хорооллын залуус болон бизнес эрхлэгчдийг дэмжих Бизнес инкубатор сургалтын төв үүд хаалгаа нээлээ. Нээлтийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл, ИТХ-ын дарга Л.Ариунтуяа нар оролцлоо. Гэр хорооллын айл өрхийн гарааны бизнесийг бойжуулахад дэмжлэг үзүүлэхээр нэн хөнгөлөлттэй түрээсийн байр талбай, хичээл, сургалтын танхимуудыг бүрэн тоног төхөөрөмжтэй нь тохижуулан хүлээлгэн өгч байгаагаараа онцлог юм.

2020.10.13
Сэлбэ дэд төвийн хүүхдүүд шинэ цэцэрлэгтээ явж эхэллээ. Чингэлтэй дүүргийн 18-р хороонд барьж ашиглалтад оруулсан 280-р цэцэрлэг 270 хүүхдийн дүүргэлттэй, 37 багш ажилтантай үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

2021.03.18
"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн захирал Ж.Сандагсүрэн Баянхошуу болон Сэлбэ дэд төвд ажиллалаа. Төслийн зохицуулагч Д.Авирмэд болон инженерийн баг Баянхошуу,Сэлбэ дэд төвүүдэд хийж гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажлууд болон төсөл хэрэгжснээр гарч буй үр дүнгүүдийн талаар танилцуулсан юм.

2021.04.09
НЗДТГ-ын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга М.Аясгалан Баянхошуу дэд төвд ажиллалаа. Түүнийг АХБ-ны Монгол дахь суурин газрын хот байгуулалтын ахлах мэргэжилтэн Арнауд Хэкман, төслийн зохицуулагч Д.Авирмэд болон төслийн инженерийн баг хүлээн авч, Баянхошуу дэд төвд өрнөж буй бүтээн байгуулалтын ажлууд болон ашиглалтад хүлээлгэн өгсөн барилгуудын үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнг танилцуулав.

2021.05.25 - 05.31
Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ажиллаж, Дэд төвүүдийн үйл ажиллагаатай танилцав. Тэрээр "Ирэх оны төсвийн хөрөнгө оруулалтыг дэд төвүүдийг хөгжүүлэхэд зарцуулна" гэлээ.

2021.10.04
Баянхошуу дэд төвд хийж гүйцэтгэсэн 6.8 км урт хатуу хучилттай авто замыг Сонгинохайрхан дүүрэгт хүлээлгэж өгөв. Энэхүү зам нь Баянхошууны эцсийн буудлаас Зүүн салааны зам хүртэл 871метр урт 20метр өргөнтэй дөрвөн эгнээ бүхий гэрэлтүүлэг, гэрлэн дохио, явган зам, автобусны буудлуудтай, борооны ус зайлуулах системтэй зам юм.

2021.12
Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийг мэдээлэл, харилцаа холбооны өндөр хурдны шилэн кабелын сүлжээнд холбох "Мэдээлэл холбооны нэгдсэн үйлчилгээний төв"-үүдийг 2021 оны 12 сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Төслийн хүрээнд Баянхошуу дэд төвд 4600м сувагчлал, 11900м шилэн кабель, Сэлбэ дэд төвд 2600м сувагчлал 19500м шилэн кабелын сүлжээг бий болгов.

2021.09.06
Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын далан сувгийн дотор ханын цутгалт болон далангийн дагуух нийт 3.01 га газарт шаварлаг хөрсийг ногоон байгууламжаар сольж, сагсан бөмбөгийн талбай, тоглоомын талбай, чийрэгжүүлэх төхөөрөмж, иргэдийн амарч суух сандал, сүүдрэвч, явган хүний зам зэргийг цогцоор нь тохижуулж ашиглалтад оруулаа.

2021.09.09
Сэлбэ дэд төвд 2020 оны хоёрдугаар улиралд ашиглалтад оруулсан Бизнес инкубатор сургалтын төвийн барилгыг нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд хүлээлгэн өглөө.

2021.10.08
Сэлбэ дулааны станц ашиглалтад орж Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн нутаг дэвсгэрийг дамнасан 158га талбайд оршин сууж буй иргэдийг дулааны эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж эхэллээ. Тус станц нь Дэд төвийн доторх улсын болон хувийн аж ахуйн нэгж, иргэд болон Дэд төвд шинээр бий болох орон сууцны хороолол, сургууль, цэцэрлэг, нийгмийн барилга байгууламжуудыг дулааны эрчим хүчээр хангах юм.

#Бид #Сэдэв

Нийтлэлч
Г.Хонгорзул

Д.Авирмэд:

ДЭД ТӨВИЙН ХӨГЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО ХАМГААС ЧУХАЛ

Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банктай хамтран "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотод Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Шархад, Толгойт гэсэн зургаан шинэ дэд төвийг байгуулж, нийслэл нэг биш олон төвтэй болно. Дэд төвтэй болсноор төвлөрөл саарч, түгжрэл буурна гэж тооцоолжээ. Үүнтэй холбогдуулан уг төслийн зохицуулагч Д.Авирмэдтэй ярилцлаа.

"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл ямар зорилготой вэ, энэ төслийн хэрэгжих үндэс юу байсан бэ гэдгээс яриагаа эхэлье.

10 жилийн хугацаанд хэрэгжиж, Улаанбаатар хотод зургаан дэд төвийг байгуулах энэ төсөл нийслэлийн гэр хороололд байгаа хүндрэлтэй асуудлыг шийдэх, тэр дундаа агаар, хөрсний бохирдол, төвлөрлийг сааруулах зорилготой. Одоо нийслэлийнхний толгойны өвчин болчихоод байгаа түгжрэлийн гол шалтгаан нь энэ хэт төвлөрөл болоод байна. Нийслэл үндсэндээ нэг л төвтэй. Сүхбаатарын

талбай тойроод төрийн захиргааны бүх байгууллага, бизнес, соёлын төв, үзвэр, үйлчилгээнүүд байгаа учраас энэ төвлөрлийг задлах шаардлага үүссэн. Иймээс зургаан дэд төвийг байгуулна. Дэд төвийн гол зорилго нь гэр хороололд хотын төв бий болгох. Аж төрөн суугаа газар орчиндоо, гэртээ ойрхон хүний хэрэгцээг хангаж байвал хотын төвийг өдөр бүр зүглэж, түгжирч байх бодит хэрэгцээгүй болно. Түүнчлэн жил бүр орон нутгаас нийслэлийг зорьж ирэх иргэдийн тоо нэмэгдэж байна. Гэр хороолол асар их тэлж, хүн ам нь өсөж, төлөвлөлт нь замбараагүй болсон нь хотыг чиглэсэн их нүүдэл суудлаас үүдэлтэй. Сүүлийн 10 жилд хагас сая хүн хөдөө орон нутгаас хотод ирж суусан. Энэ зах хязгааргүй тэлж байгаа гэр хороололд амьдарч байгаа иргэдэд төрийн үйлчилгээ, соёлын үйлчилгээ авахад хүндрэлтэй байна. Тиймээс гэр хороллыг орон сууцжуулах суурь нөхцөлийг бий болгох инженерийн дэд бүтцийг бүтээх зорилт тавьсан. Гэр хороололд инженерийн хувьсгал хийнэ. Ингээд гэр хороллын айлуудыг орон сууцжуулахад мэдээж ашиглалтын зардал гарна. Энэ зардлыг нөхөхийн тулд иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, энд бизнесийн төвлөрөлийг бий болгох ёстой. Тийм учраас бүх төрлийн засварчин, оёдолчин, үсчин гэх мэт мэргэжлийн сургалт явуулж, гарааны бизнес эрхлэх боломж нөхцөлөөр хангана. Ажилгүй иргэдийг ажилтай болгохоор Германы хамтын ажиллагааны байгууллагатай хамтраад 5000 ур чадвартай ажилтан бэлтгэх нэг сая еврогийн сургалтыг зохион байгуулж байна. Гэр хороллын иргэдийн сэтгэлгээ рүү ажиллах хэрэгтэй байна.

Тус хөтөлбөр гурван үе шатаар хэрэгжихээр төлөвлөгдсөн. Төслийн нэгдүгээр үе шат дуусаж байна. Энэ хүрээнд ямар ажлууд хийсэн бэ?

Манай төслийн хамгийн эхний үе шат нь Баянхошуу, Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалт. Тухайлбал, Баянхошуу дэд төв бол нийтдээ 165 га-д төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар 3400 өрх амьдарч байна. Үүнийг гурав дахин нягтаршуулах дэд бүтцийг бид хийж байгаа. Өөрөөр хэлбэл, тэнд 10500 айл амьдрахад сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээнд шаардлагатай барилга байгууламжийг барих дэд бүтцийн тооцооллыг хийгээд баригдаад дуусаж байна. Баянхошуу дэд төвийг төвлөрсөн дулаанд холбож байгаа юм. Гэр хороололд нэг тулгардаг асуудал нь цахилгааны хүчдэл унах. Одоо гэр хороололд орон сууц бариад, бүтээн байгуулалт хийх гэхээр тогны хэрэглээ хүрдэггүй. Иймээс тус дэд төвд цахилгааны дэд станц барьж байна. Харин дулаан хангамжийн хувьд Баянхошуу дэд төвд 1000 метр кубын усан сан барьж дуусгасан. Энэ санд усаа татаж төвлөрүүлээд, уулын оройгоос хэрэглэгчид рүүгээ түгээх юм. Мөн 6.7 км ариутгах татуурга буюу бохирын шугам татсан. Үүнийхээ хүрээнд "Хилчин" хотхоныг төвлөрсөн дулаанд холбосон. "Хилчин" хотхон төвлөрсөн шугамгүйн улмаас жил бүр нийслэлийн төсвөөс 500 саяас нэг тэрбум төгрөгийн татаас авдаг байсан цаг дуусан. Айл өрхүүд нь ч өнтэй өвөлжиж, тухтай аж төрдөг боллоо. Өрхүүд нам даралтын зуух хэрэглэж, долоо хоногт хоёр удаа хэрэглээний халуун ус авдаг байсан бол өдөр бүр хэрэглээний халуун ус авах боломжтой болж дулаанд зарцуулах зардал нь буурлаа. Одоо Баянхошуу дэд төвд буй сургууль, цэцэрлэг, эмнэлэгийг төвлөрсөн дулаанд холбоход жилдээ 10 мянган тонн нүүрсийг хэрэглээнээсээ хасаж байна. Ингэхээр олон жил ярьсан гэр хороллын агаарын бохирдлыг бууруулах боломж бий болно. Харин төвлөрлийг бууруулах тал дээр Нийслэлийн орон сууцны корпорацитай хамтран Баянхошуу дэд төвд газрыг орон сууцаар солих хөтөлбөр хэрэгжүүлж 5.1 га газрыг чөлөөлсөн. Тэр газарт манай дэд бүтцийг ашиглаад орон сууц барих нөхцөл бүрдэж байгаа юм.

Харин Сэлбэ дэд төвийн тухайд ямар ажил хийгдэж амжив?

Сэлбэ дэд төвийн хувьд Сүхбаатар дүүргийн нэг, Чингэлтэй дүүргийн хоёр хороог хамарсан 156 га-д төлөвлөлт хийж байгаа. Энд дулаан хангамжийн бие даасан эх үүсвэр барьсан. Сэлбэ дулааны цахилгаан станц 28 мВт-ын хүчин чадалтай, утаагаа 99 хувь шүүдэг фильтртэй гэдгээрээ онцлог. Тэгэхээр үнс хаях, тортог унах гэсэн асуудал гарахгүй. Одоогийн байдлаар найман хэрэглэгчийг төвлөрсөн дулаанд холбоод байна. Дахиад нэмэлтээр айл өрх, худалдааны төвүүд дулаанд холбогдож байгаа юм. Ингэхээр Баянхошуу болон Сэлбэд жилдээ 20 мянган тонн нүүрсийг хэрэглээнээс хасаж байгаа гэсэн үг. Баянхошуу, Сэлбэ дэд төвд гэр хороллыг төвлөрсөн бохирын шугамд холбосноор хөрсний бохирдлыг бууруулахад онцгой нөлөө үзүүлэх тооцоотой. Одоо бид 1200 орчим нэгж талбайг чөлөөлчихөөд байгаа. Жорлонгийн тоо 1200-аар буурсан гэсэн үг.

Гэр хороололд томоохон бүтээн байгуулалт хийхэд газар чөлөөлөлт хамгийн том бэрхшээл болдог. Танай төсөлд ч ийм бэрхшээл учирч байна уу?

Манай хот төлөвлөлтийн нэг алдаа нь Улаанбаатар хотын газрыг хувьчилсан явдал. Дэлхийн ихэнх хот газраа хувьчлаагүй байдаг. Яагаад гэхээр, газар нь төрийн мэдлийнх байсан тохиолдолд төлөвлөлт хийхэд хялбар байдаг. Манайх газраа өмчлүүлснээс гадна албадан чөлөөлөх ямар ч хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй. 40, 50 мянгатыг барихад улсын газар байсан учраас "Аман хуур" кинонд ирээдүйн хадмынхаа хашааг хүргэн нь тракторaар түрж байгаа үйл явдал гардаг шүү дээ. Энэ цаг үе бол үндсээрээ өөр. Сайн дурын үндсэн дээр тохиролцох ганцхан арга замтай. Соном гуайнх хашаагаа орон сууцаар сольдог үр дүн нь бол адилхан. Иргэдтэй сайн дурын үндсэн дээр тохиролцох өөр арга зам байхгүй. Манай төслийн хувьд Азийн хөгжлийн банкны зарчмаар хэрэгжиж байгаа учраас газар чөлөөлөх үнэлгээ өндөр байдаг. Энэ төслийг хэрэгжүүлэхэд газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудал хүндрэл учруулж байсан. Газар чөлөөлөлтөд иргэдийн оролцоо чухал. Иргэд оролцохгүйгээр энэ дэд төвүүдийг хөгжүүлэх боломжгүй. Төслийн хүрээнд газраа чөлөөлсөн иргэдийн бараг 80 хувь нь орон сууцанд орсон байна. Ер нь энэ гэр хороллыг байшин хороолол болгох, хотын төв шиг хөгжүүлж нийслэлийн төвлөрлийг саармагжуулах, иргэдийн эрүүл аюулгүй орчин, бизнес, соёлын төвлөрлийг бий болгоход газар чөлөөлөлт хамгаас чухал. Ийм учраас газраа чөлөөлсөн иргэдэд талархаж байна. ►

Нэг үе шатанд хоёр дэд төв байгуулахаар төлөвлөсөн юм байна. Төслийн хоёрдугаар үе шат буюу Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвийг байгуулах ажил эхэлсэн үү?

Хоёрдугаар үе шат 2018 онд эхлээд дэд бүтцийн ажил хийгдэж байна. Дамбадаржаа дахь дэд төвийн ажил 2022 оноос эхлээд 2023 онд дуусна. Толгойт, Шархад дэд төвүүдийн зураг төслийн ажлууд дуусаж байна. Ажлын үйл явцын хувьд эхлээд ТЭЗҮ хийгээд нарийвчилсан зураг төслөө гаргана. Зураг төслийн дараагаар тендерийн үйл ажиллагаа руу ордог. Энэ үйл ажиллагаа 3-4 сар үргэлжилдэг. Тендерт шалгарсан компани барилга угсралтаа зуны улиралд хийнэ. Төслийн II, III үе шатыг 2023 онд багтааж дуусгахаар төлөвлөсөн. Хамгийн гол асуудал нь нийслэл хангалттай санхүүжилт тавьж өгөх ёстой. Үгүй бол дэд төвүүдээс нэг, хоёроороо хасагдах нөхцөл байдал бий болно. Нийслэлээс яагаад хангалттай санхүүжилт тавьж өгөх ёстой вэ гэхээр энэ гэрээг хэдийгээр Азийн хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан ч гэлээ нийслэл эргэн төлөлтийг хариуцаж энэ төслийг явуулах үүрэг хүлээсэн. Үүнийг төсөвтөө тусгах ёстой. Энэ жил нийслэлийн төсөвт хангалттай мөнгө тавьж чадвал бид төслөө дуусгах юм.

Азийн хөгжлийн банкнаас хэдий хэмжээний зээлийг ямар нөхцөлтэйгөөр олгосон юм бэ. Зээлийн нөхцөл хэр таатай вэ?

Нийт санхүүжилт 320 сая ам.долларoор эхэлж байсан. Одоо газар чөлөөлөлт зэргийн мөнгийг оруулбал 344 сая доллар болж байгаа юм. Үүнээс 160 сая ам.доллар нь Азийн хөгжлийн банкны нэн хөнгөлөлттэй зээл. 20 жилийн хугацаатай, жилийн хоёр хувийн хүүтэй, эхний таван жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй. 60 сая ам.доллар нь Европын хөрөнгө оруулалтын банкны зээл. Бас жилийн хоёр хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай. Үлдсэн 100 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг нь нийслэл өөрөө хариуцах юм. Тэгэхээр үндсэндээ нийт хөрөнгө оруулалтын 220 сая ам.доллар нь зээлийн хөрөнгө гэсэн үг.

Нийслэлийн төвлөрлийг бууруулж гэр хорооллыг хөгжүүлэхийн тулд төрийн зарим байгууллагыг нүүлгэхээр шийдэж байгаа. Дан ганц төрийн байгууллага гэлтгүй бизнесүүдийг ч гэр хороолол руу нүүлгэх шаардлага байна. Үүн дээр хэрхэн анхаарч байна вэ?

Жишээлбэл, Баянхошуу дэд төвд Барилга хот байгуулалтын яам очно гэжд шийдчихсэн байж байна. Энэ мэт төрийн байгууллагуудыг дэд төв рүү гаргаснаар тэрнийг дагасан бизнесүүд нүүнэ. Үүнийг дагаад ажлын байр нэмэгдэнэ. Ажлын байраа дагасан орон сууц баригдах гэх мэтээр хөгжөөд явах боломж бий болж байгаа юм. Энэ зургаан дэд төв дээр хийсэн дэд бүтцийг ашиглаж яаж гэр хорооллыг хөгжүүлэх вэ, зөвхөн дэд бүтцээ хийгээд орхих биш цаашдаа бизнес, соёлын төвлөрлийг бий болгохын тулд татварын бодлого, хууль эрх зүйгээр яаж дэмжих вэ гэдэг асуудал чухал. Дэд төв, хотын захад очиж бизнес хийвэл хөнгөлөлт үзүүлэх зэргээр иргэдийг бодлогоор дэмжиж байж энэ дэд төв цаашид хөгжинө. Жишээ нь, дэлхийн улс орнуудад хотын төвдөө өртөг өндөртэй, хотын зах руугаа зарлага бага байдаг. Тийм учраас иргэд нь татвар багатай хотын захад амьдрах сонирхолтой. Энэ төслийг дан ганц дэд бүтцийн төсөл гэж харж болохгүй. Гэр хорооллыг хөгжүүлнэ гэдэг бол хот төлөвлөлтийн томоохон шийдэл. Тэрний хамгийн эхний асуудал нь л төвлөрсөн инженерийн дэд бүтэцтэй болгох юм. Харин гэр хорооллыг инженерчлэх ажлын тулах цэг, тулгуур үндэс нь хүний дайтай амьдрах хүний жам ёсны хүсэл юм. Бүтээн байгуулалтын хүчин чадлын хамгийн их хувь нь он удаан жилээр овоорч хуримтлагдсан асуудал бэрхшээлээс хотыг, хотын хүн амыг чөлөөлөхөд оршиж байна гэсэн үг. Гэр хорооллыг инженерчлэх нь орчны бохирдол, амьдралын чанар, замын түгжрэлээс чөлөөлөх чөлөөлөлт юм.

Нийтлэлч
О.Даваасүрэн

Улаанбаатарын хүмүүс:
ХОТ ДОТОРХ “ХОТ”-ЫН ИРГЭД

Манай улсын нийт хүн амын тэн хагас нь нийслэлд оршин суудаг. Тэдгээрийн 70 орчим хувь нь гэр хороололд амьдарч байна. Гурван сая хүний талыг нь “шингээж” байгаа нийслэлд нэгдсэн стандарт, дэд бүтэц нэн дутагдалтай. Улмаар хотын төв, хотын зах гэх хоёр өөр “ертөнц” нэг улсын нэг хотод бий болжээ. Уг нь Улаанбаатар нэг л хот учир Дэнжийн мянгад мөрдөгдөж буй стандарт Зайсанд ч үйлчлэх учиртай. Харамсалтай нь, манайд тийм биш. Тэр ч бүү хэл, гэр хороллын айл өрхийн ундны ус, нүхэн жорлонгийн асуудлыг ч цэгцэлж дөнгөөгүй байтал XXI зуун гараад хориод жил өнгөрөв.

Гэхдээ дээрх асуудал тэр чигээрээ “буглачихаагүй” байна. Гарц, шийдэл гялтайж, эхнээсээ эмхэндээ орж байгааг энэ нийтлэлдээ хөндье. Алслагдсан хороллын айл өрхийн орчимд нэг цэгийн үйлчилгээ, сургууль, цэцэрлэг цогцлоож, инженерийн шугам сүлжээ, засмал зам, тоглоомын талбай, спорт цогцолбор зэрэг элдэв асуудлыг нь цэгцлэх зорилготой цогц хөтөлбөр хэрэгжээд, үр дүнгээ өгөөд эхэлжээ.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлээр “Гэр хороллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл хэрэгжиж эхэлсэн юм. Тус төсөл гурван үе шаттайгаар нийт арван жилийн хугацаанд үргэлжлэх аж. Төслийн I шатны хүрээнд хотын хойд бүсийг Баянхошуу, Сэлбэ дэд төв болгон хэсэгчлэн хөгжүүлэх бөгөөд Дэд төвүүдэд нийгмийн болон инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын олон ажил хийгдсэн байна. Тодруулбал, мянга шахам айл өрхийн хашаа байшин, жорлон, амбаар байсан газрыг чөлөөлөөд, буурин дээр нь инженерийн шугам сүлжээ, зам, цэцэрлэг, Нэг цэгийн үйлчилгээний төв, спорт цогцолбор зэргийг барьж, байгуулжээ. Ийнхүү он удаан жил овоорч, хураагдсан лаг шавар, хог шороо, тоос тортогноосоо сая нэг салах боломж бүрдсэн талаар тухайн орчмын иргэд учирлаж байлаа. Үнэхээр ч Баянхошуу орчимд бичил хот сүндэрлэжээ. Айл өрх, албан байгууллагууд төвийн дулаанд холбогдож, сургууль, цэцэрлэгүүд хананаасаа халуун усаа авч, хүүхдүүд олон улсын стандартад нийцсэн ясли, цэцэрлэгт хичээллэж, үйлдвэрлэл хөгжиж, бизнес эрхлэгчид бойжиж байна. Тун сайхан.

Засмал зам, шахмал түлшний гавьяагаар утаа, тоос ч татарчээ. Нэг цэгийн үйлчилгээний ачаар хотын төвийг зорих хөл хөдөлгөөн ч багассан гэнэ. Энэ талаар бид хэд хэдэн эх сурвалжаас тодруулж, бүтээн байгуулалтын ашиг тусын талаар лавласан юм.

►

Л.Цэрэндолгор:

Утаа, тоос хамгийн багадаа хоёр дахин багассан

"Хилчин" хотхоны оршин суугч

Манай хотхон ашиглалтад орсноосоо хойш 10 гаруй жил уурын зуухаар халсан. Тухайн үед утаа тоос ихтэй, амьдрах орчин нөхцөл хүнд байсан. Гэрийн тагт, цонх дагтаршсан тоос, тортог болчихдог байв. Өвлийн хүйтэнд халаалт тасарна, ус, дусаал гоожно гээд бэрхшээл их. Халуун ус ч ирэхтэй үгүйтэй л байдаг байсан. Харин 2020 онд төвлөрсөн дулааны шугамд холбогдоод дээрх асуудал бүрэн шийдэгдсэн. Одоо бид хотын төвийн орон сууцанд амьдарч байгаа юм шиг л ая тухтай байна. Утаа, тоос хамгийн багадаа хоёр дахин багассан. Орчин нөхцөл цэвэрхэн болчихоор байрны гадна тохижилт, орцны засвар үйлчилгээ зэрэгт анхаарч эхэлсэн. Орчин сайжраад зогсохгүй мөнгө, санхүүгийн хувьд ч хэмнэлттэй байхаар ажиглагдсан.

Ө.Анхбаяр:

Газраа чөлөөлөөд насан туршийн ажлын байртай болсон

Амьжиргаа дэмжих хөтөлбөрт хамрагдаж, өрхийн бизнесээ хөгжүүлж буй

Газраа чөлөөлсөн иргэдийг "Амьжиргаа дэмжих хөтөлбөр" нэртэй сургалтад хамруулсан юм. Шинэ орчинд шилжин суурьшихад нь ажлын байр, амьдрах боломжийг нь хангах зорилготойгоор тус ажлыг эхлүүлсэн юм билээ. Би дээрх сургалтад хамрагдаад оёдол хийж сурсан. Би тухайн үед ажилгүй байсан. Сургалтад хамрагдсанаас хойш өөрөө өөртөө ажлын байр бий болгож, санхүүгийн эх үүсвэртэй болсон. Одоо бүр өрхийн бизнес болж өргөжиж байна. Би өрх толгойлсон эмэгтэй. Хань маань гурван жилийн өмнө өөд болсон. Түүнээс хойш хүүхдүүдээ хүнээс дутаахгүй өсгөж байгаа маань оёдол, эсгүүртэй холбоотой. "Амьжиргаа дэмжих хөтөлбөр" гэх сургалтаа амжилттай төгсөөд, оёдлын машинаар шагнуулж байлаа. Газраа зах зээлийн үнэлгээгээр үнэлүүлж чөлөөлөөд, насан туршийн ажлын байртай болсон. Иргэдийн амьжиргааг дэмжиж, амьдрах боломж, нөхцөлийг нь дээшлүүлж байгаад их баяртай байдаг.

Г.Чанцалдулам:

250 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг ашиглалтад орсон

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 261 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

Манай цэцэрлэг “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 оны арванхоёрдугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Цэцэрлэг ашиглалтад орсноор хүүхдүүдэд суралцах боломж нээгдсэн төдийгүй иргэд ажлын байртай болсон. Манайх 41 ажилтантай. Тэдний 80 гаруй хувь нь Сонгинохайрхан дүүргийн наймдугаар хорооных. Хорооныхоо ажилгүй иргэдийг ажлын байраар хангах зорилгоор багаа бүрдүүлсэн. Манай цэцэрлэг 250 хүүхдийн хүчин чадалтай. Найм болон тавдугаар хорооны хүүхдүүдийг цэцэрлэгтээ хамруулдаг. Одоогоор 350 хүүхэд хамрагдаж байна. Ажилгүй, гэртээ хүүхдээ хардаг байсан хүмүүс хүүхдээ цэцэрлэгтээ өгөөд, өөрсдөө ажиллах боломж бүрдсэн. Тиймээс энэ цэцэрлэг 40 гаруй хүнийг л ажлын байраар хангаж байгаа юм биш. Өмнө нь хүүхдээ хараад ажил хийж чаддаггүй байсан олон хүн ажиллах боломжтой болсон. Манай цэцэрлэг тохь тухтай, олон улсын стандартад нийцсэн учир эцэг, эхчүүд хүүхдүүдээ хамруулах их дуртай байдаг. Хүүхдээ сургаад, өөрөө цэцэрлэгтээ ажиллаж буй ээж ч олон бий. Дэд төвийн хүрээнд манай энэ хавь хотын төв шиг л болсон. Нэг цэгийн үйлчилгээ, мэдээлэл холбооны төв, засмал зам, засвар үйлчилгээ гээд шаардлагатай бүхэн нэг дор төвхөнөсөн. Бохир, ус, дулаанаа ч бүрэн шийдсэн. Ингэхээр иргэдийн амьдрах боломж бүрэн хангагдаж байгаа юм. Өмнө нь бичиг, цаас хөөцөлдөх гээд хотын нэг захаас нөгөө зах руу яваад, түгжрэлд хамаг цагаа суулиулдаг байсан шүү дээ. Одоо бол эндээ бүх асуудлаа шийдвэрлээд, ажлаа цэгцлээд амьдрах бүрэн боломжтой болсон.

Л.Гэрэлт-Од:

Манай энэ хавь хотын төвөөс дутахааргүй болсон

Баянхошуу бизнес инкубатор төвийн түрээслэгч

Манайх 2007 оноос хойш оёдол хийж эхэлсэн. 2016 онд урлан болж өргөжсөн. Өмнө нь хотын төвд ажилладаг байлаа. Хотын А зэрэглэлд үйл ажиллагаа явуулдаг байсан учир үйлчлүүлэгч ихтэй байдаг байсан. Баянхошуу бизнес инкубатор төв ашиглалтад орсноос хойш энд байрлах болсон. Хэдий хотын төвөөс зайтай ч үйлчлүүлэгч тасардаггүй. Таньдаг, мэддэг хүмүүс нь зориод ирдэг. Баянхошуу дэд төвийн хүрээнд маш олон бизнес бойжиж байгаа. Зөвхөн бизнес эрхлэгчдэд ч бус иргэдэд ч тустай. Захын дүүрэгт хүмүүст үйлчилгээг ойртуулж байгаа нь том давуу тал. Өмнө нь ажилдаа ирж, очих гэж өдөрт хоёр, гурван цагийг авто замын түгжрэлд өнгөрүүлдэг байсан. Харин одоо гэрийнхээ хажууд ажиллах боломж бүрдсэн. Манай энэ хавь хотын төвөөс дутахааргүй болсон. Дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн. Энд тэндгүй засмал замтай болсон. Өөрт шаардлагатай бүх үйлчилгээг нэг дороос авах боломж нээлттэй. Энэ хавийн иргэдэд хотын төв рүү явах хэрэгцээ, шаардлага бараг байхаа больсон. ►

С.Оюунтүлхүүр:

Бизнес инкубатор төв асар их дэм болж байна

Баянхошуу бизнес инкубатор төвийн түрээслэгч

Манайх монгол гутал, гөлөм хийдэг. Бид Дэд төвийг анх ашиглалтад ороход нь л энд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Эхний гурван сар биднээс түрээсийн төлбөр ч аваагүй. Энд ирэхээсээ өмнө гэрэл, агааргүй подвальд үйл ажиллагаа явуулдаг байлаа. Харанхуй, бүгчим гээд бэрхшээл их байсан. Бидэнд ч, үйлчлүүлэгчид ч хүндрэлтэй. Харин энд ирснээс хойш орчин нөхцөл сайжраад, ажиллахад урам зориг, ая тухтай байна. Мөн бизнесээ хөгжүүлэхээр өнгөрсөн есдүгээр сараас эхлээд сургалтад сууж эхэлсэн. Цаашдаа зөвхөн монгол гутал, гөлөм биш хэвлүүрт хийдэг бусад төрлийн гутал бэлтгэдэг болохыг зорьж байгаа. Ажлын байр Дэд төвд болохоор мэдээлэлтэй ойр байдаг нь их давуу талтай. Ковид19-ийн хүнд үед ажлын байрыг маань хадгалж байсанд талархаж байна. Хоёр жил орчим орлого, ашиг тасалдаад амаргүй байсан ч ажилгүй болчих вий гэж сэтгэл зовиноогүй. Баянхошуу бизнес инкубатор төв өөртөө ажлын байр бий болгоод амьдралаа авч явахад асар их дэм болж байна.

Ч.Алтансүх:

Дэд төвийн хүрээнд төвлөрсөн халаалтад холбогдлоо

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургуулийн захирал

67 дугаар сургууль 1976 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа. Хэсэгчилсэн инженерийн байгууламжийн хүрээнд нэг компаниас халаалтаа авдаг, бохироо соруулдаг байсан. Мөн зөөврийн устай байж байгаад хэдэн жилийн өмнө цэвэр усанд холбогдсон. Харин 2019 оноос Баянхошуу дэд төвийн хүрээнд төвлөрсөн халаалтад холбогдлоо. Ингэснээр тохь тух сайжраад зогсохгүй санхүүгийн хувьд асар их хэмнэлттэй байна. Өмнө нь халаалтаа авахын тулд хувийн компанид сард 29 сая төгрөг төлдөг байсан. Харин төвлөрсөн дулаанд холбогдсоноор халаалтын төлбөр гэж дунджаар 5 сая төгрөг төлж байна. Ийнхүү халаалтын зардал дөрөв дахин хямдарсан. Манай сургууль халуун усанд анх удаа холбогдож байгаа. Халуун ус авч, хэрэглээд сар болох гэж байна. Өмнө нь үйлчлэгчид цэвэрлэгээ үйлчилгээ хийхэд хүндрэлтэй байсан. Усаа халаана, буцалгана. Ингэхээр тог, цахилгааны төлбөр ч их гардаг. Харин одоо халуун устай болчихсон болохоор цэвэрлэгээ, үйлчилгээтэй холбоотой асуудлын оронд хогоо ангилах, анги, сургуулиа цэцэгжүүлэх тухай яригдаж байна. Яригддаг асуудлын түвшин дээшилсэн. Манай сургууль өмнө нь сард 2-3 сая төгрөгийн зардал гаргаж бохироо соруулдаг байсан. Бохир соруулах бас их хүндрэлтэй. Өвөл хөлдөнө, хавар хайлаад, гадагш нэвчинэ. Одоо бол энэ асуудал бүрэн шийдэгдсэн. Зардал ч хэд дахин хямдарсан.

Дэд төвийн бүтээн байгуулалт зөвхөн нэг сургуульд гэхэд л ийм их ашиг тус өгч байна. Манай энэ хавийн хэд, хэдэн сургууль төвлөрсөн халаалт, цэвэр бохир усанд холбогдсон. Улмаар тухайн орчмын айл өрхүүдэд ч ая тухтай амьдрах боломж, нөхцөл нэмэгдэж байгаа юм. Хамгийн наад зах нь хийгдэж буй бүтээн байгуулалтаас шалтгаалж утаа багассан. Манай сургуульд утаа хэмжих төхөөрөмж бий. Тэндээс харахад, сургууль орчмын утаа гурван жилийн өмнөхтэй харьцуулахад хамгийн багадаа 50 хувь буурсан. Ингээд утаа, тоос, дулаан, бохирын асуудал шийдэгдээд ирэхээр соёл, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага өндөрсөж байгаа юм. Товчхондоо соёл төлөвшиж байна. Хүүхдүүдийн эрүүл мэндэд ч тустай.

#Ахуй #Хандлага

Нийтлэлч
С.Лхагвасүрэн

Ногоон дээвэр

Тэнгэр баганадсан сүрлэг цамхагийн оройд ургамал ногоо алаглаж, жигүүртэн чуулсан бяцхан баянбүрд цогцлоох санааг 30 жилийн өмнө Германы уран барилгачид гаргажээ. Их хотын нүргээн чимээг шингээж, халуун агаарыг хөргөхөд тустай энэхүү шийдэл эдүгээ хот төлөвлөлтийн гол чиг хандлага болж буй. Энэ талаар маш товч мэдээллийг уншигч танд өгье.

Цаг агаарын харьцангуй тааламжтай нөхцөлтэй Азийн улс орнууд "Ногоон дээвэр"-ийн хөдөлгөөнд урьтаж нэгдсэн бол АНУ, Европын хотууд ч уур амьсгалын өөрчлөлтдөө зохицсон аргаар дээврээ ногооруулахыг илүүд үзэх болжээ. Ногоон дээвэр нь барилгын орой дээр цэцгийн саванд ургамал тарихаас тэс өөр ойлголт. Өөрөөр хэлбэл, барилгын дээвэр хэсэгт үржил шимт хөрс суулгаж зүлэг, бут, цэцэг, мод суулгасан тусгай давхарга бий болно гэсэн үг. Зарим хотод барилгын нүүрэн талыг зүлэгжүүлж, ногооруулдаг нь экологид эергээр нөлөөлөхийн зэрэгцээ үзэмжтэй харагддаг.

Орчин үеийн архитектурын ногооруулах тусгай аргаар бүтээсэн дээврийн ачаар өрөө тасалгааны дуу чимээ ойролцоогоор 40 децибелээр буурдаг аж. Ердийн дээвэр зуны улиралд хэт халж гадаргуу дээрх агаарын хэм цельсийн 50 градус хүрдэг тул ургамал ногоо тарьж арчлах ямар ч боломжгүй. Тэгвэл ногоон дээврийн ургамал ногооноос ялгарсан чийг ууршиж, агаарын хэмийг 30 градусаас доош барьдаг сайн талтай. Мөн дээд давхрын өрөөнүүд зуны улиралд хэт халахаа больж, сэнс, агааржуулагч ажиллуулах шаардлагагүй болох тул эрчим хүчинд ч хэмнэлттэй шийдэл юм. Ер нь агаарын бохирдол, тоосжилт зэргээс үүдээд суурин газрынхан агааржуулагч, агаар шүүгчийг улирал харгалзахгүй өргөн хэрэглэдэг. Гэтэл ийм төрлийн цахилгаан хэрэгсэл олшрох тусам хотын агаар таван хэмээр нэмэгддэг аж.

Нийт барилгынхаа дээврийн 20 хувийг ногооруулж дөнгөвөл зуны улиралд агаарын чанар мэдэгдэхүйц сайжирч, температур 3-5 хэмээр буурна, дагаад эрчим хүчний хэрэглээ ч багасна. Харин хүйтэн сэрүүний улиралд ногоон дээврийн олон давхарга тусгаарлагч, дулаан баригчийн үүрэг гүйцэтгэн бороо цасны үйлчлэлээс хамгаалах тул дээврийн эдэлгээ уртасч, халаалтын зардал ч буурах нь дамжиггүй ажээ.

Б.Сүхбаатар:

Хэт төвлөрлийг сааруулж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно

Нийслэлийн Засаг даргын орлогч, Хот байгуулалтын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Сүхбаатартай ярилцлаа.

Нийслэл нэг төвт хотоос олон төвт хот болох зорилтыг тавиад багагүй хугацаа өнгөрчээ. Чамгүй ч ажил амжуулсан байна. Эндээс ярилцлагаа эхлэх үү?

Тэгье ээ, энэ зорилтыг дэвшүүлж байсантай харьцуулахад өнгөрсөн хугацаанд багагүй ажил амжуулжээ. Бид зургаан дэд төв, 26 олон нийтийн төв байгуулахаар төлөвлөсөн. Дэд төвүүдийн ажил эхнээсээ дуусч байгаа бол олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ-ийг хийж байна.

Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ажил амжилттай хийгдээд дуусах шатандаа орлоо. Одоогоор эхний ээлжийн дэд бүтцийн ажлуудыг дуусгаад хүлээлгэж өгсөн байна. Дамбадаржаа, Дэнжийн мянга дэд төвийн тухайд ажил дунд шатандаа орсон. Харин Шар хад, Толгойтынх шугам сүлжээ, замын трасс гээд зураг төслийн шатандаа явна даа.

Дэд төв гэхээр тэнд барилга бариад байна уу. Яг юуг хэлээд, цаашдаа яаж хөгжинө гэсэн үг вэ?

Төвлөрлийг сааруулж, төрийн болон соёл урлагийн үйлчилгээг иргэдэд ойртуулах нь Дэд төвийн зорилго. Баянхошуунд амьдардаг хүн төрийн үйлчилгээ авах эсвэл үзвэр үйлчилгээнд хамрагдахын тулд зайлшгүй хотын төв рүү эсвэл Зайсан явах шаардлагагүй болно гэсэн үг. Хотын төвд байдаг бүх л үйлчилгээг амьдарч байгаа газар нь бий болгохыг зорьж байна. Сургууль, цэцэрлэг, үзвэр үйлчилгээ, худалдааны төвүүдийг бий болгож, ажлын байрыг тийшээ чиглүүлэх учиртай.

Баянхошуу дэд төвөөр жишээлж тайлбарлая. Эхний талбар дээр 5.8 га газар чөлөөлж төсөл хэрэгжүүлж байгаагийн 1.2 га нь ногоон байгууламж. Тэнд төрийн байгууллагуудыг аваачина. Орчин нь сайхан болоод, зам харгуй нь жигдрээд, үерийн далан шуудуутай болчихвол тэнд хүн очиж ажиллана шүү дээ. Төрийн үйлчилгээ ч ойртоно. Ийнхүү хотын бас нэг төвийг тэнд барихыг зорьж байгаа юм.

Нэг судалгааны дүн хэлье. Сүүлийн таван жил хамгийн их орон сууц баригдсан, хамгийн борлуулалт өндөртэй дүүргийг жагсаахад, Хан-Уул тэргүүлж байна. Араас нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг ордог. Харин Сонгинохайрхан төвийн зургаан дүүргээсээ тав, зургаад нь орж байна. Барилгын компаниуд инженерийн шугам сүлжээ байхгүйтэй холбоотойгоор Сонгинохайрханд орон сууц барихгүй байна. Зөвхөн Хан-Уул дүүрэг рүү, тэр тусмаа Яармаг руу хэт төвлөрөл явсны гор одоо гарч, түгжрэл гаарч байгаа юм. Тэгэхээр энэ төвлөрлийг задалж, тойрсон Дэд төвүүд байгуулж ачааллаа хуваарилах ёстой. Тиймээс Дэд төвүүдийн ажлыг явуулж байна.

Гэхдээ төр үйлчилгээний байгууллага бариад явахгүй биз дээ?

Төр дангаараа хэзээ ч хийхгүй. Хувийн хэвшилтэйгээ хамтарна.

Хувийн хэвшил очих уу. Сонирхох юм уу?

Сонирхол одоо л эхэлж байна. Хоёр хүчин зүйл байгаа юм. Нэгдүгээрт, орчин нөхцөл өөр болж эхэллээ. Ногоон байгууламжтай болж, зам харгуй, дэд бүтцийн асуудал жигдэрлээ. Хоёрдугаарт, борлуулалтын дэмжлэг болон хөнгөлөлттэй зээл. Өөрөөр хэлбэл, барилга байгууламжид чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн бодлогууд тийшээ чиглэнэ. Орлогод нийцсэн ногоон орон сууц төслийн хүрээнд хөнгөлөлттэй зээлүүд олгоод эхлэхээр барилгын компаниуд очно шүү дээ. Тэнд барилга баривал хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, борлуулалтдаа санаа зовохгүй байх боломж бүрдэнэ гэсэн үг. Талх хийдэг хүн ч хамгийн түрүүнд борлуулалтаа л боддог. Худалдан авагч байгаа эсэхийг чухалчилна. Тиймээс борлуулалтын дэмжлэгтэй явж байгаа энэ төсөл дээр барилгын салбаруудаа ирж ажиллана гэж бид төлөвлөж байгаа.

Бид Дэд төвүүдийн дэд бүтцийн ажлын дараа "Орлогод нийцсэн ногоон орон сууц"-ны төсөл хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Улаанбаатар хотод 10 мянга гаруй айлын орон сууцыг барихаар төлөвлөж байна. Гэхдээ Дэд төв, орон сууцны төсөл хоёр тусдаа төслүүд шүү. Эхнийх нь дэд бүтцээ хийж байгаа бол хоёр дахь нь хийсэн ажил дээрээ орон сууцны бодлого хэрэгжүүлье гэж байгаа юм.

Та ногоон орон сууц гэж ярианд цөөнгүй дурдлаа. Энэ хүрээнд яг юу хийнэ гэсэн үг вэ. Ногоон орон сууц гэж ямар орон сууцыг томьёолж байгаа юм бэ?

Ногоон орон сууц гэхээр юун түрүүнд цахилгаан, дулаан, усыг хэмнэдэг байх ёстой. Хэрэглээний хэмнэлт нь хамгийн багадаа 20 хувь байвал зохилтой. Мөн баригдах барилгын материалаасаа эхлээд бүх л зүйл нь ногоон тал руугаа чиглэсэн байна. Гаднах тохижилт, орчин ч ногоон байх ёстой. Барилгын насжилтыг ч анхаарах нь зүй. Өмнө нь хүмүүс орон сууц барихдаа чанарыг орхигдуулдаг байсан. Улмаар барилгуудын насжилт хурдан дуусаж байна. Зарим хүн "Бид 2015 онд барьсан барилгад орсон. Тав, зургаан жилийн болж байхад муудаад эхэллээ" гэдэг. 2010 оноос хойш барьсан барилгууд тав, арван жилийн дараа ашиглалтын шаардлага хангахгүй болох эрсдэл их бий. Тиймээс иргэдийн орлогод нийцүүлж байр барихдаа хэрэглээний зардал бага, чанар сайн байх ёстой. Гэхдээ чанартай, насжилт урттай орон сууц барих хэрэгтэй ч орлого багатай иргэдийг орон сууцанд хамруулах шаардлагатай. Тиймээс "Орлогод нийцсэн ногоон орон сууц" төслийг Дэд төвүүд дээрээ хөгжүүлж байна.

Нэг зүйлийг тодотгоход Дэд төвүүд дээр орлогын хувьд холимог хэлбэрээр орон сууцны бодлого хэрэгжих ёстой. Өртөг өндөр орон сууцнууд ч баригдана гэсэн үг. Тэгж байж бидний төлөвлөлт зөв болно. Ихэвчлэн орлого багатай иргэд рүү чиглэсэн орон сууц ашиглалтад орохоор дараа нь бүсчлэл, нийгмийн бодлогын хувьд буруу болно.

Одоогоор хоёр Дэд төвийн ажил дуусан уу?

Хоёр нь дуусах шатандаа явж байна. Баянхошуу үндсэндээ дуусчихлаа. Сэлбэ дуусах шатандаа орсон. Давуу тал, ололт их бий. Цөөнгүй байгууллагуудын утаа гаргадаг янданг буулгаж эхэллээ. Нийслэлчүүд агаарын бохирдлыг бууруулахын тулд одоогоор сайжруулсан шахмал түлшийг хэрэглэж байна. Гэхдээ урт хугацаандаа инженерийн шугам сүлжээнд холбох ёстой. Орон сууцжуулах ч хэрэгтэй. Үүний тулд зайлшгүй дэд бүтэц хэрэгтэй. Гэхдээ зүгээр дэд бүтэц тавиад хэрэггүй юм байна. Дэд бүтэцтэйгээ хамт бусад ажлыг ч хийх нь зөв юм байна гэж төлөвлөсөн. Улмаар Дэд төвүүдийгээ холбосон замуудыг хийж байгаа. ►

Цахилгаан, дулаан бол хөгжил. Дулааны хангамжгүй газар хөгжил дэвшлийн талаар мянга яриад ч нэмэргүй. Улаанбаатар хотын гэр хорооолод 200 мянга гаруй айл аж төрдөг. Эдгээр өрхөд тулгардаг олон асуудал шийдлээ хүлээсээр буйн нэг нь дулаан хангамжийн асуудал юм.

Хананаасаа халуун усаа авч, хаяанаасаа дулаанаа хангуулах нь гэр хорооллынхны хүсэл. Өнөөдөр Улаанбаатар хотын хүн амын 60 хувь нь нүхэн жорлонтой, халуун усгүй, төвлөрсөн дулаангүй амьдарч байна. Гэр хорооолод инженерийн шугам сүлжээ байхгүй учраас гал түлэхээс өөр аргагүй. Гал түлэхээр нүүрс хэрэглэнэ, утаа гарна. Нийслэлчүүдийн эрүүл мэндэд хор хөнөөл учруулсаар байгаа зүйл бол утаа. Харин гэр хорооллыг төвлөрсөн дулаанд холбочихвол яндан алга болно. Яндангүй бол утаагүй. Тиймээс гэр хорооолод дулааны станц, шугам сүлжээ хэрэгтэй. Түүнчлэн агаар, ус, хөрсний бохирдол, хүрээлэн буй орчны доройтол зэргээс үүдэн хүн амын олонхийн амьдралын бодит хэрэгцээг үндэслэн гэр хорооллыг инженерийн дэд бүтэцтэй болгох зайлшгүй шаардлага тулгарчээ.

Азийн хөгжлийн банк, НЗДТГ-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх, зургаан Дэд төвтэй байхаар төлөвлөсөн.

Тус зургаан дэд төвд, 28 мВт, 63 мВт, 80 мВт чадалтай гурван дулааны станц барина. Үүний нэг нь "Сэлбэ" дэд төвийн гурван зуух бүхий 28 мВт хүчин чадалтай, олон улсын стандартад

Нийтлэлч
Г.Хонгорзул

ЯНДАНГҮЙ БОЛ УТААГҮЙ

нийцсэн дулааны станц. 2017 онд эхэлсэн энэ станцын ажил одоо дуусаж, бүрэн хүчин чадлаараа ажиллахад бэлэн болжээ.

"Сэлбэ" дулааны станцын зураг төсөл зохиогчоор ШУТИС-ийн Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ажиллаж, техникийн хяналтын гүйцэтгэгчээр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ ажилласан. Ийнхүү зураг төсөл бэлэн болж 2019 онд барилга угсралтын ажил эхэлжээ. Ийнхүү 2021 оны есдүгээр сард тус Дэд төвийн ажил 95 хувийн гүйцэтгэлтэйгээр туршилтаар ашиглалтад орж, Сэлбийн дэнжийн зарим аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж эхэлсэн бол өдгөө барилга угсралтын ажил бүрэн дуусжээ.

Нийслэлийн Засаг даргын орлогч
Ж.Сандагсүрэн

Энэ бол маш том бүтээн байгуулалт. Хэдхэн жилийн өмнө гэр хорооолд дулааны станц баригдаж гэр хорооллыг дулаанаар холбож, энэ хавийн хүмүүс төвлөрсөн дулаантай болно, хананаасаа халуун ус авна гэдэг зүйлийг ярихад үлгэр мэт хүлээж авдаг байсан. Өнөөдөр энэ зүйл бодитоор төлөвлөгдөж хэрэгжээд үр шимийг нь иргэд хүртэж байна.

Сэлбэ дэд төвийг 156 га газарт төлөвлөсөн. Сэлбэ дулааны станц энэ хэсгийг дулаанаар хангах үүрэгтэй. Ингэснээр Долоон буудал, Сэлбэ болон зуслангийн чиглэлийн зам дагуух гэр хорооллын аж ахуйн нэгж төвлөрсөн дулаан хангамжид холбогдоно гэсэн үг. Тус станц ашиглалтад орсноор Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт амьдарч байгаа 3000 өрх айл, 100 гаруй аж ахуйн нэгж дулааны станцаас найдвартай дулааны эх үүсвэрээр хангагдах боломжтой болж байгаа юм. Эдгээр айл, албан байгууллагууд эхнээсээ төвлөрсөн дулаанд холбогдоод эхэлжээ. Тухайлбал, Чингэлтэй дүүргийн 280 дугаар цэцэрлэг, 35 дугаар сургууль, 50 айлын орон сууц, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлэгчдийн хөгжлийн төв зэрэг барилгуудыг дулаанаар хангаад байгаа юм. Одоо Сэлбэ дэд төвд 3260 айл өрх амьдарч байна. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу ирээдүйд тус Дэд төв дэх айлын тоо 7000-д хүрч, 300 гаруй аж ахуйн нэгжтэй болж хөгжинө гэсэн тооцооллоор уг станцыг төлөвлөжээ. Түүнчлэн энэ дулааны станц баригдсанаар тэнд үйл ажиллагаа явуулах байгууллагын тоо нэмэгдэнэ. Дэд бүтцэд холбогдсоноор орон сууцнууд баригдаж олон иргэн ажлын байртай болно. Гэр хороолол байшин хороолол болж хотын төвлөрөл саарч, түгжрэл буурна гэж төсөл хэрэгжүүлэгчид үзэж байгаа юм.

Дулааны инженер
Х.Цолмонбаяр

Сэлбэ дэд төвийн дулаан хангамжийн төслийн хүрээнд 28МВт хүчин чадалтай Дулааны станцаас гадна 15 ширхэг ус, дулаан хуваарилах төв болон дулаан дамжуулах 13км урт шугам сүлжээний ажил бүрэн хийгдэж ашиглалтанд хүлээлгэн өгөөд байна. Өнөөдрийн байдлаар дулааны станц нийт хүчин чадлынхаа 15 хувиар ашиглалтын 45 инженер техникийн ажилтаны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Дулааны станц бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед 70-80 хүний орон тоо шинээр бий болох юм. Сэлбэ дулааны станцын гол онцлог нь байгальд ээлтэй, тоос тортог гаргахгүй, үнсийг 99.9% шүүх PTFE төрлийн уутан үнсний шүүлтүүр, эргэлдэх буцламтгай үед шатаах зуух, усыг бүрэн цэвэршүүлэх төхөөрөмж гэх мэт орчин үеийн дэвшилтэт технологиор бүтээгдсэн. Түүхий нүүрсний хэрэглээг жилдээ 20 мянган тонноор бууруулах судалгаатай ба нүүрс хадгалах битүү агуулахтай тул тоосжилт үүсгэдэггүй агаар орчинд хамгийн бага нөлөөлөл үзүүлэх дулааны станц гэдгийг мэргэжилтнүүд тодотгож байна. Нүүрсийг бүрэн шатаах технологи нэвтрүүлсэнээр нүүрсний дутуу шаталтаас ялгарч агаар мандалд хаягддаг нүүрсхүчлийн дан ислийн /CO/ хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулан байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бодитойгоор бууруулж байна.

Сэлбэ дулааны станцын нэг онцлог нь тортог гаргахгүй, байгальд ээлтэй, үнсээ 99.9 хувь шүүх технологиор бүтээгдсэн. Түүхий нүүрсний хэрэглээ жилдээ 15 мянган тонноор бууруулах судалгаатай, агаар орчинд хамгийн бага нөлөөлөл үзүүлэх дулааны станц гэдгийг мэргэжилтнүүд тодотгож байна. Үнсээ бүрэн шүүдэг Сэлбэ дулааны станц нь байгальд ээлтэйгээс гадна хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулахгүй гэдгээрээ онцлогтой юм байна.

Тав тухтай, эрүүл аюулгүй орчинд аж төрөх нь хүний туйлын хүсэл. Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэх иргэдийн тоо жилээс жилд нэмэгдсээр буй. Буруутгах аргагүй. Үүнийгээ дагаад нийгмийн олон асуудал тулгарч байгаа. Шилжин суурьшигчид дассан, төрсөн нутгаасаа хотыг зориод гарахдаа сайхан амьдралд л тэмүүлдэг. Гэвч тэдний олонх нь хотын захын гэр хорооолд орчны бохирдол дунд ирж суурьшдаг. Техник технологи хөгжсөн дэлхийн метрополитан хотын хувиар Улаанбаатар хотын гэр хорооолол төвлөрсөн дулаанд холбогдох цаг болжээ.

#Матар

Шог зураач
С.Цогтбаяр

Нийтлэлч
MURDOC

Шүүмжлэлдээ шүүмжлүүлсэн минь

Би гэдэг хүн өөрийгөө магтах тун дуртай хүн байгаа юм. Гэхдээ магтах ч гэж дээ, үнэн нь тэр юм л даа. Миний шүүмжлэх сэтгэлгээ асар сайн хөгжсөн болохоор арга байж уу дээ. Юуг л бол юуг л шүүмжилнэ шүү дээ. Дутагдлын хажуугаар дуугүй өнгөрдөггүй энэ зан маань олон юман дээр оволзож гарч ирээд байдаг юм. Сая зун Өглөөний гудамж гэдэг юм нээгдсэнийг зад шүүмжиллээ. Өөрөө очоогүй байж л фэйсбүүк дээрээ бичиж гарлаа л даа. Улсын мөнгийг үр ашиггүй зарж, үрж дуусласа гэвч бичсэн лайк ч, шэйр ч байдаггүй. Уур хүрээд хотын захиргааг зорилгоо. Хаана байна тэр гудамжч чинь, харуулаадахаачээ, хаана байна аа Сумъяабазар аа гэвч л хотын захиргааны хаалгыг балбаж гарлаа шүү. Гэтэл хотын захиргааны харуул залуу "Ах аа, арын гудамжинд байгаа шд" гэдэг юм байна. Очоод үзлээ овоо сайхан, дориун үйлчилгээтэй аятайхан газар байдаг байгаа. Гэхдээ миний шүүмжлэлт сэтгэлгээ тэр дайны гудамжийг шүүмжлэхдээ л шүүмжилнэ шүү дээ. Гудамж яахаараа өглөөний гэдэг нэртэй байдаг юм. Шөнийнх нь тэгвэл хаана байна. Очмоор байна гэвч л бууж гарлаа. Тэгсэн хотынхон дараа нь шөнийн гудамж нээчихсэн байна лаа. Гэхдээ зүгээр ээ, миний сэтгэлгээ дийлдэх биш. Өдрийн гудамжаа нэхчихсэн. Яадгийм.

Өө тэгсэн саяхан зурагтаар ярьж байна шүү. Эрээний боомт хаагдсан гэвч л сурвалжлагч охин ярихаар нь би нөгөө муу охиныг шүүмжиллээ шүү. Муусайн хятадууд хулхи бараагаараа Монголын мөнгийг сорж байгаа, хохь нь. Ингээд тэд нар орлогогүй боллоо. Үндэсний үйлдвэр хөгжих үндэс суурь бүрдлээ гэвч л фэйсбүүктээ бичээд тавьлаа. Сүрхий олон лайк, шэйр авчийшүү. Хөх толбот монголчууд хөгийн хятадуудаас гуйхгүй амьдарна. Тэд нарын л орлого багасаж байгаа биз гэвч л миний дэмжигчид мянга мянгаараа нэмэгдлээ. Би ч дотроо бодлоо. Ер нь л нүдийг нь олоод шүүмжилжээ. Энэ миний ухааныг уу ухааны юм бодоод байжийтал байдал бишидлээ. Монголд тарьдаг нарийн ногоонууд тасраад, буллд орсон чинь нарийн ногоогүй лавшаа хийж идэх болдгийм байна. Өө тэгсэн хятадуудаас илүү бид нар хохирч байна гэвч миний нөгөө постыг буруутгаад эхэллээ. Угаасаа над шиг шүүмжлэлт сэтгэлгээтэй хүмүүс байгаа учраас л энэ нийгэм урагшлахаас хойш гэсэнчүү юм бодоод өнгөрсөн юмдаг.

За тэгтэл, хот олон төвтэй болжоогоо гэсэн мэдээ бас гарлаа шүү. За ёстой худлаа, тийм юм байдаггүймаа гэвч л би шүүмжлэлээ өрнүүллээ. Энэ удаад илүү далайцтай шүүмжлэхээр шийдэж өөрийн фэйсбүүкээс гадна хоёр ч тролл хаягаа ашиглалаа. Хэзээ хот олон төвтэй байсын гэвч л шүүмжлэлээ эхлүүллээ шүү. Баянхошуу, Сэлбэ, Толгойт, Шархад, Дэнжийн мянга, Дамбадаржаа хотын төв болчуул Сүхбаатарын талбай юу болохын гэвч л шүүмжлэлээ цааш нь өргөжүүллээ. Тэгсэн ёстой газар авсангүй. Төвлөрлийг сааруулаад, түгжрэлийг бууруулахад Дэд төв шиг хэрэгтэй юм байхгүй. Хотын төв рүү түгжирч ирж авдаг байсан үйлчилгээг хотын захад адилхан авч болохгүй юм гэж үү. Гэр хороллынхон гэхээр хананаасаа халуун ус аваад, хаяанаасаа халуун дулаанаа авч болохгүй гэвч бүр эсрэгээрээ намайг шүүмжилдэг юм. Нээрээ бодоод байхад манай Баянхошууныхан хотын дүүргийн иргэд байж "Хот руу орчоод ирий" гэж ярьдаг, байс гэвч л хотын төв рүү орж кино үздэг, хот руу орж кофе шопод суудаг байсан юм билээ. Дэд төвөө дагаад дэд бүтэцтэй, дэд бүтцээ дагаад үзвэр үйлчилгээтэй болчуул хоёр цаг түгжирч хотын төв орох хэрэг ч надад алга л даа.

ШИНЭ ДЭД ТӨВ
УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

ГЭР ХОРООЛОЛД
ИНЖЕНЕРИЙН ХУВЬСГАЛ

Хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 1,
Амарын гудамж-2, Соёлын төв өргөө, Г-корпус-415

Утас:
(976)-70003099

Баянхошуу, Сэлбэ дэд төвийн утас: 75003099

И-мэйл:
info@ub-subcenter.mn